



World Health
Organization



АШУҮИС
Анагаахын Шинжлэх Ухланы Үндэсний Их Сургууль
1942

“АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ОНЦГОЙ ТАТВАРЫН ТООЦООЛОЛ”

Судалгааны тайлан



Улаанбаатар хот
2022 он

ТАЛАРХАЛ

Монгол хүн амын архины хэрэглээ, түүнээс үүдэх эрүүл мэнд, эдийн засгийн эрсдэлийг бууруулах бодлогын боловсруулах ажлын нэг хэсэг болгон “Архи, согтууруулах ундааны онцгой татварын үнэлгээ, тооцоолол” хийх ажлыг санаачлан, холбогдох талуудыг нэгтгэн хамтран ажилласан Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар, хамт олонд талархал илэрхийлье.

Судалгааны арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, ДЭМБ-ын Женев дахь төв оффисийн мэргэжилтэн Иван Блечер болон судалгааны өгөгдлийн санг бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх үйл явцад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Сангийн яам, Статистикийн үндэсний хороо, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хамт олонд судалгааны багийн зүгээс талархал илэрхийлье.

Судалгааны баг

СУДАЛГААНЫ БАГ, БҮРЭЛДЭХҮҮН

Захиалагч:

Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар

Судалгааны санхүүжүүлэгч:

ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар

Хэрэгжүүлэгч

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль

Эрүүл мэндийн хөгжлийн зуун ассоиаци

Зөвлөх баг:

Т.Мөнхсайхан, АУ-ны доктор, МУ-ын Ерөнхийлөгчийн эрүүл мэнд, нийгмийн бодлого, спорт хариуцсан зөвлөх

Н.Сүмбэрзул, АУ-ны доктор, профессор, АШУҮИС-ийн Эрдмийн сургууль

О.Чимэдсүрэн, АУ-ы доктор, профессор, Эрүүл мэндийн хөгжлийн зуун ассоиаци

Судалгааны тайлан бичсэн

Т.Ариунтуяа, НЭМ-ийн доктор, Эрүүл мэндийн хөгжлийн зуун ассоиаци

Б.Оюунбилэг, АУ-ы доктор, АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль

М.Ундррам, АУ-ы доктор, АШУҮИС-ийн Анагаах ухааны сургууль

Б.Энх-Амгалан, Эдийн засгийн ухааны доктор, дэд профессор, МУИС-ийн Бизнесийн сургууль

Судалгааны мэдээ, материал цуглуулсан

Б.Батзориг, НЭМ-ийн доктор, АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль

Б.Оюунбилэг, АУ-ы доктор, АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль

Б.Сүхзориг, Судлаач, Эрүүл мэндийн хөгжлийн зуун ассоиаци

М.Ундррам, АУ-ы доктор, АШУҮИС-ийн Анагаах ухааны сургууль

Судалгааны тайланг хянан тохиолдуулсан

О.Чимэдсүрэн, АУ-ы доктор, профессор, Эрүүл мэндийн хөгжлийн зуун ассоиаци

С.Болормаа, ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар

АГУУЛГА

“АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ОНЦГОЙ ТАТВАРЫН ТООЦООЛОЛ”

СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ	4
ҮНДЭСЛЭЛ	8
СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ	11
СУДАЛГААНЫ ҮР ДҮН	22
МОНГОЛ УЛС ДАХЬ АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ, ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	22
Хүн амын архи, согтууруулах ундааны хэрэглээ, хүртээмж.....	22
Архи, согтууруулах ундааны зах зээлийн өнөөгийн байдал.....	25
Архи, согтууруулах ундааны үнэ, онцгой татварын үнэлгээ.....	28
АРХИНЫ ҮНЭ, ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН МЭДРЭМЖИЙГ СУДАЛСАН ҮР ДҮН....	35
Архины үнэ болон борлуулалтын хамаарал	35
Архины үнэ /25-аас 40 хувийн хатуулагтай/ болон 1л архинд ногдох татварын хамаарлын шинжилгээ.....	38
Архины татварын орлогод нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ /25-аас 40 хувийн хатуулагтай/.....	38
Архины үнийн мэдрэмжийг QUAIDS загварыг ашиглан тооцсон үр дүн.....	40
АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНД ТАТВАР ТООЦОХ АРГЫГ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН.....	44
АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭНЭЭС ҮҮДЭЛТЭЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨЛӨӨЛӨЛ.....	49
Хүн амын дундах архины хэрэглээ.....	49
Архинаас шалтгаалсан өвчлөлийн хандлага.....	50

“АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ОНЦГОЙ ТАТВАРЫН ТООЦООЛОЛ” СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ

ДҮГНЭЛТ

1. 2008 оноос хойш архи, согтууруулах ундаа (АСУ)-ны хэрэглээ тасралтгүй өсч 21-с дээш насны 1 хүнд жилд 54 л ноогдож байгаа нь үнэ хямд, дотоодын үйлдвэрлэл 36 сая литрээс 120 сая литр хүртэл нэмэгдсэнтэй холбоотой байна.
2. Дотоодын үйлдвэрийн цагаан архины нэрлэсэн үнэд эзлэх онцгой татварын хувь хэмжээг 2008 онд 38% байсан бол 2020 онд 39.5% байгаа нь өнгөрсөн 13 жилийн хугацаанд бүтээгдэхүүний үнэд эзлэх татварын хэмжээнд тодорхой өөрчлөлт гараагүй байгаа тул Татвар тооцох аргыг эрс өөрчлөх шаардлагатай харуулж байна.
3. Архи, согтууруулах ундаанд ногдуулсан онцгой татвар нь үнийг бодитоор өсгөж, хүн амын хэрэглээг бууруулахад биш, харин энэ төрлийн бүтээгдэхүүний зах зээлийг дэмжихэд чиглэсэн байна.
4. АСУ-ны татвар ноогдуулсан өөрчлөлт нь үнийн мэдрэмжгүй, өрхийн орлогын өсөлтийг гүйцэхгүй байна.
5. АСУ-д татвар тооцож буй арга, хэлбэр нь тохиромжгүй байсан нь үйлдвэрлэл, борлуулалтын цэг тоон тогтвортой, тасралтгүй өсч, хүртээмж нэмэгдэн “архи- хэрэглэгч” орон болсон.
6. Согтууруулах ундааны үнэ тухайн бүтээгдэхүүний хатуулаг болон эзлэхүүний хэмжээтэй уялдаагүй бөгөөд борлуулалтын үнэд эзлэх онцгой татварын хувь олон улсын жишигтэй харьцуулахад 2-3 дахин бага байна.
7. Цаашид архинд ноогдуулах татварыг хатуулаг (40-60 хувь болгох), стандарт уултанд (1 стандарт уултын үнэ) суурилан тооцож нэмэгдүүлэх шаардлагатай.
8. Хүн амын эрүүл мэндэд бодитой хувь нэмэр оруулах, өвчлөл нас баралтыг бууруулахын тулд нэгж стандарт уултын үнийг хамгийн багадаа 1000 төгрөг, нэгж хатуулагт ноогдох онцгой татварын хэмжээг 380 төгрөг болгон нэмэгдүүлэх шаардлагатай.

9. АСУ-ны хөтөлбөрийн урт болон богино хугацааны үр дүн (дундаж наслалт, өвчлөл, нас баралт) хамгийн өндөр байх бүлэг нь эрэгтэйчүүд байна.
10. АСУ хэрэглээг бууруулахын тулд санал болгож буй (татвар, борлуулах өдөр, цагийн хязгаарлалт, зорилтот бүлэгт чиглэсэн) арга хэмжээг цогцоор үр дүнтэй хэрэгжүүлбэл 2030 он гэхэд 1 хүнд ноогдох архины хэрэглээ 2- 2.5 дахин буурах боломжтой байна.

ЗӨВЛӨМЖ

А. БОДЛОГЫН ТҮВШИНД:

1. Архидалт, түүний хор хөнөөлийг үр дүнтэй бууруулахын тулд онцгой албан татварыг нэгж стандарт уулт болон нэгж хатуулагаар тооцож тогтоох:
 - Архинд ноогдуулах татварыг хатуулаг (40-60 хувь болгох), стандарт уултанд (1 стандарт уултын үнэ) суурилан тооцож нэмэгдүүлэх,
 - Шар айраг, дарсны үнэд эзлэх татварыг 20 хувь хүртэл нэмэгдүүлэх,
2. Архидалтын эсрэг үндэсний стратеги, бодлогын чиглэлийг тодорхой болгох, түүнтэй уялдуулан жил бүр онцгой албан татварын хэмжээг нэмэгдүүлэх, шинэчлэх,
3. Архи, согтууруулах ундааны онцгой татварын хэмжээг жилийн инфляци, хэрэглээний үнийн индексээс давуулж тогтоох, тогтмол шинэчлэх,
4. Архи, согтууруулах ундааны олдоц, хүртээмжийг бууруулах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
5. Хууль бус архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаанд тавих хяналтыг сайжруулах,
6. Татварын бодлоготой хослуулан бодлогын олон талт интервенцийг цогцоор, хамтрагч талуудын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх.

Б. ОЛОН ТАЛТ ИНТЕРВЕНЦИЙГ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНД ТУЛГУУРЛАН ХЭРЭГЖҮҮЛЭХ

1. Архи, согтууруулах ундааны борлуулалт, хэрэглээг хязгаарлахын тулд:
 - Архи худалдаалахгүй өдрийн тоог нэмэгдүүлэх /сард 2 удаа болгох/,
 - Архи согтууруулах ундаа худалдаалах цагийн хязгаарлалтыг нийслэл, аймаг, сумдын түвшинд тохируулах хийх,

2. Архи тогтмол хэрэглэгчдээс илүүтэйгээр архи ууж эхлэхээс сэргийлсэн бодлогоруу анхаарах,
3. Архигүй Ирээдүй бодлогыг дэмжих:
 - ЕБС, МСҮТ, коллеж, их, дээд сургуулийн хөтөлбөрт архи согтууруулах ундааны эрүүл мэндийн хор хөнөөл, зохистой хэрэглээний талаар сургалт явуулах, эрүүл зан үйлд төлөвшүүлэх,
 - Архигүй ирээдүй цогц интервенци боловсруулах,
 - Баасан гаригийн гэр бүлийн өдөр болгон эрүүл зан үйлийг дэмжих,
 - Спорт, соёлын нэгж, төвүүдийн гэр бүлд чиглэсэн үйлчилгээг нэмэх,
4. Байгууллага, гэр бүлд эрүүл мэндийг дэмжих зан үйлийг бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах,
5. Хүн амын ялгаатай бүлгүүдэд архи, согтууруулах ундааны хортой хэрэглээнээс үүдэх эрүүл мэндийн үр дагаварыг ухуулан таниулах, сурталчилах.

В. НОТЛГООНД СУУРИЛАСАН БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ

1. Архины шалтгаант эрсдэлт хүчин зүйлс, үнийн мэдрэмж, орлогын мэдрэмж, татварын үнийн мэдрэмжийг тодорхойлох гэх мэт суурь судалгаануудыг хийх, шинжлэх ухааны нотолгоог нэмэгдүүлэх,
2. АСУ-ны хэрэглээг бууруулах чиглэлээр боловсруулсан бодлого, түүний хэрэгжилтийг үнэлэн, нотолгоонд тулгуурлан үргэлжүүлэх, шинэчлэх, өөрчилж хэвших,
3. Архины татварын өөрчлөлтөөс үүдэн гарах үр нөлөөний судалгааг нийгэм, эдийн засгийн ялгаатай бүлгээр судлах,
4. Архи, согтууруулах ундааны зар сурталчилгааны өнөөгийн нөхцөл байдлыг судлах,
5. Архины эрүүл мэнд болон эдийн засагт үзүүлж буй үр нөлөөллийг цогц байдлаар өргөжүүлэн судлах - зардал үр өгөөжийн судалгаа, архины шалтгаант эдийн засгийн тооцоо, нийгмийн өөр өөр бүлгүүдээр задлан судлах.

СУДАЛГААНЫ БАГ

2022.02.14

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Тооцоолол хийсэн алхам	18
Хүснэгт 2 Харьцуулалт хийсэн хөтөлбөрүүд	19
Хүснэгт 3 Ашигласан мэдээ материал	21
Хүснэгт 4 Архи, согтууруулах ундаа жижиглэнгээр худалдаалж, үйлчилж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо, нэг цэгт ногдох 21-ээс дээш настай хүн амын тоо	24
Хүснэгт 5 21-ээс дээш настай 10000 хүн амд ногдох их эмч, эрүүл мэндийн байгууллага, архи согтууруулах ундаагаар үйлчлэх цэгийн тоо	25
Хүснэгт 6 Монгол улс дахь ундаа үйлдвэрлэл, аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, борлуулалт, 2008-2020 он, тэрбум төгрөгөөр	26
Хүснэгт 7 Архи, согтуулах ундааны дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ, 2008-2020 он, мянган литрээр	27
Хүснэгт 8 Архи, согтууруулах ундааны импортын хэмжээ, 2008-2020 он, сая литр	28
Хүснэгт 9 Архины үнийн өөрчлөлт ба борлуулалтын орлогын өсөлтийн симуляц	36
Хүснэгт 10 Архины татварын орлогод нөлөөлөгч хүчин зүйл	39
Хүснэгт 11 Архи согтууруулах ундаа тамхины үнийн болон солбицох үнийн мэдрэмж	41
Хүснэгт 12. Шар айрагт тооцсон татварын тооцоо	45
Хүснэгт 13. Татвар тооцох аргуудыг харьцуулсан байдал	47
Хүснэгт 14 Архины шалтгаант зарим оношийн бүлгийн хуримтлагдсан тархалт, хүйсээр	51
Хүснэгт 15 Хөтөлбөр хэрэгжүүлснээр сэргийлэх боломжтой өндөр эрсдэлтэй архи хэрэглэдэг хүний тоо (мянган хүн)	52
Хүснэгт 16 Хөтөлбөр хэрэгжүүлснээр сэргийлэх боломжтой өвчлөлийн тоо (2021-2051 он, мянган хүн амаар)	53
Хүснэгт 17 Аврагдах боломжтой ХЧА-аар тооцсон жилүүд	55
Хүснэгт 18 Эрүүл мэндийн салбарын зардлын хэмнэлт, өнөөгийн үнэ цэнэ 3% тооцсон (тэрбум төгрөг)	56

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Нийт хүн амаас жилд нэг хүнд ногдох архи, согтууруулах ундааны хэмжээ, литрээр, нэр төрлөөр, 2008-2020 он	23
Зураг 2 21-ээс дээш настай нэг хүнд 1 жилд ногдох архи, согтууруулах ундааны хэмжээ, литрээр, нэр төрлөөр, 2008-2020 он	24
Зураг 3 Нэг литр шар айрагт ноогдох онцгой албан татвар, төрлөөр	30
Зураг 4 Дотоодын үйлдвэрийн 1 л цагаан архины үнэ ба жилийн борлуулалтын хэмжээ, 2007-2020 он	31
Зураг 5 Дотоодын үйлдвэрийн 1 л шар айрагны үнэ ба жилийн борлуулалтын хэмжээ, 2011-2020 он	32
Зураг 6 Өрхийн орлогын өөрчлөлт ба 0.5л бүхий 38 хувийн хатуулагтай архины үнийн өөрчлөлт	38
Зураг 7 Согтууруулах ундааны үнэ, татварын хувь хэмжээ	45
Зураг 8 Хүн амын дундах архины эрсдэлтэй түвшинд хэрэглэдэг бүлгийн хэтийн төлөв	51
Зураг 9 Элэгний өмөн өвчлөлийн урт хугацаанд буурах чиг хандлага	55

ҮНДЭСЛЭЛ

Согтууруулах ундаа нь хүн төрөлхтний дунд олон зуун жилийн турш, өргөн хэрэглэгдэж ирсэн хүнийг донтуулах, сэтгэцэд нөлөөлөх шинж чанартай бодис юм. Архийг хэтрүүлэн хэрэглэх нь хувь хүний эрүүл мэндэд хортой төдийгүй, эргэн тойрны хүмүүст дам байдлаар нөлөөлж, улмаар нийгэм, эдийн засагт дарамт үүсгэдэг байна.^{1,2}

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-ын мэдээллээр архи хэтрүүлэн хэрэглэсний улмаас дэлхийд 1 жилд 3 сая буюу 1 минутад 6 хүн нас барж байна.^{3,4,5} 2010 онд зохион байгуулагдсан Дэлхийн эрүүл мэндийн 63 дахь удаагийн чуулганаар Архи согтууруулах ундааны хортой хэрэглээг бууруулах дэлхийн стратегийг хэлэлцэн баталж, хэрэгжүүлсэн 10 жилийн хугацаанд дэлхийн хүн амын архи, согтууруулах ундааны хэрэглээнд мэдэгдэхүйц бууралт гараагүй бөгөөд 15 ба түүнээс дээш насны нэг хүнд ногдох хэрэглээ 2005 онд 5.5 литр байсан бол 2010 онд 6.3 литр, 2018 онд 6.2 литр болж харьцангуй тогтвортой байсаар байна.

Дэлхийн хэмжээнд согтууруулах ундааны хэрэглээ нь хүн амын эрүүл мэндэд хор хөнөөлтэй, эрсдэлт хүчин зүйлсийн нэг болж байна.^{2,3} Ялангуяа согтууруулах ундааны хэрэглээ нь эх, хүүхдийн эрүүл мэнд, халдварт өвчнүүд (ХДХВ, вируст гепатит, сүрьеэ), халдварт бус өвчин, сэтгэцийн өвчин, осол гэмтэл, хордлого зэрэг өвчнүүдийн өвчлөл эндэгдлийг нэмэгдүүлж байдаг. Иймээс Тогтвортой хөгжлийн зорилгын эрүүл мэндийг дэмжих зорилтын 3.5-д “Урьдчилан сэргийлэх, эмчлэх ажлыг бэхжүүлэхэд мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэх, түүний дотор мансууруулах бодис, согтууруулах ундааны хор хөнөөлтэй хэрэглээ

¹ World Health organization. Global status report on alcohol and health 2018. <https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/274603/9789241565639-eng.pdf?ua=1>

² 5. World Health organization. Alcohol pricing in the WHO European Region, update report on the evidence and recommended policy actions. <https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/336159/WHO-EURO-2020-1239-40989-55614-eng.pdf?sequence=1&isAllowed=y&fbclid=IwAR0vif8dQVYz4VU3P3BVAKxvFcHs9HTHuw5911azuwOmeA70BIH7zGfyinQ>

³ Tatsuya Takeshita. Prevention of alcohol-related health harm in the workplace. *IndHealth*. 2017 Sep; 55(5): 403–405. Published online 2017 Oct7. doi: 10.2486/indhealth.55-403.

⁴ Alcohol consumption: levels and pattern. https://www.who.int/substance_abuse/publications/global_alcohol_report/profiles/jpn.pdf?ua=1

⁵ Tackling Harmful Alcohol Use Country note – Japan <https://www.oecd.org/japan/Tackling-Harmful-Alcohol-Use-Japan-en.pdf>

бууруулах”-аар заасан байдаг бөгөөд шалгуур үзүүлэлтэд “Мансууруулах бодис хэрэглэгчдийн эмчилгээнд хамрагдалтын хувь, тухайн жилд 15, түүнээс дээш насны нэг хүнд ногдох согтууруулах ундааны хэмжээ, литрээр” тооцохоор гаргажээ.^{1,2}

Улс орнууд архины хэрэглээнээс үүдэн хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгэм-эдийн засагт гарах сөрөг нөлөөг багасгахын тулд олон талт арга хэмжээ, бодлогыг хэрэгжүүлж байна. Тухайлбал, согтууруулах ундаа худалдан авах боломжийг хязгаарлах, үнэ болон татварын механизмаар дамжуулан эрэлтийг багасгах, согтуугаар жолоо барихыг хориглох, олон нийтэд эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөөг таниулах, мэдлэг олгох үр дүнтэй бодлогыг дэмжих, архинаас хамааралтай хүмүүст хүртээмжтэй үр дүнтэй эмчилгээг хүргэх, зэрэг олон хувилбаруудаас өөрийн орны онцлогт тохирсон, зардал үр ашиг хамгийн өндөр, боломжит хөтөлбөрийг сонгон хэрэгжүүлж байна.

Эдгээр олон хөтөлбөрүүдээс “үнэ болон татварын механизмаар дамжуулан эрэлтийг бууруулах” бодлогыг дэлхийн олон оронд хэрэгжүүлэн, үр дүнгээ өгсөн байна. Үр дүнтэй татварын бодлогоор дамжуулан согтууруулах ундааны хэрэглээг хянах, үнийг бодитоор нэмэгдүүлэх, архины үнэ инфляц, орлогын өсөлтөөр өндөр байхаар зохицуулсан байна. Архины татвар нь улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх, архины үнийг зохицуулах давхар үүрэгтэй. Улс орнууд согтууруулах ундааны хатуулаг, эзэлхүүн, доод үнийг тогтоох зэрэг согтууруулах ундааны татварын өөр өөр бүтцийг ашигладаг онцгой татвар тогтоож байна. Зарим улс оронд маш хямд согтууруулах ундаа худалдахаас сэргийлдэг нэмэлт үнийн хяналтын арга хэмжээнүүд байдаг байна.

Монгол улсад нийт хүн амын өвчлөл, нас баралтын голлох эрсдэлт хүчин зүйлийн нэгд архи, согтууруулах ундааны хэрэглээ ордог бөгөөд жил бүр 16 мянга гаруй хүн энэ шалтгааны улмаас өвчилж, гэмтэл бэртэл авдаг, энэ шалтгаант нас баралт хүн амын нас баралтын 6.8 хувийг эзэлж, нэг хүнд ногдох архи, согтууруулах ундааны хэрэглээ дэлхийн дунджаас өндөр хэвээр байна.

Манай улсад архидан согтуурахтай тэмцэх тухай хууль анх 1994 онд батлагдсан ба 2000 онд шинэчлэгдсэн хувилбар нь одоо хүртэл хүчинтэй хэрэгжиж байна. Уг

хуулийн хүрээнд архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр 2003 онд батлагдаж одоог хүртэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Түүнчлэн амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний нэгдүгээр болон хоёрдугаар хөтөлбөр болон 2020 онд хэрэгжиж дууссан Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд архины хэрэглээг бууруулах зорилтууд тусгагдсан боловч архи согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, эрүүл зохистой хэрэглээг сурталчлах үндэсний хөтөлбөр болон бодлогын цогц тогтолцоо одоогоор бүрдээгүй байна.

Монгол улсад 2007 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Онцгой албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар архи, согтууруулах ундаанд онцгой албан татвар ногдуулах болсон. Уг хуульд 2007 оноос 2021 оны 7 сарын 6-ныг хүртэл архи, согтууруулах ундаанд ногдуулах онцгой татварын хувь, хэмжээтэй холбоотой нэмэлт өөрчлөлт нийт 6 удаа орсон бөгөөд эдгээр өөрчлөлтүүд нь хүн амын хэрэглээг бууруулах нөлөө үзүүлсэн эсэх нь тодорхойгүй байна.

ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр Монгол улсын архи, тамхины онцгой албан татварын үнэлгээ хийх олон салбарын ажлын хэсэг 2016-2017 онд ажиллаж, тухайн үеийн татварын хувь хэмжээ, макро эдийн засгийн байдалд үнэлгээ, зөвлөмж өгч байсан. Энэхүү ажлын үргэлжлэл болгож, дээр дурдсан ДЭМБ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө болон бүсийн зорилттой уялдуулан үндэсний стратеги боловсруулах хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага тулгач байна.

Судалгааны Зорилго

Архи, согтууруулах ундааны онцгой албан татварын хэмжээг нэмэгдүүлэх замаар хүн амын эрүүл мэнд болон эдийн засагт гарах нөлөөллийг судлах, тооцох.

Зорилтууд

1. Дэлхийн улс орнуудын архи, согтууруулах ундааны хэрэгжүүлж буй татварын бодлогыг тоймлон судлах

2. Монгол улс дахь архи, согтууруулах ундааны зах зээлийн өнөөгийн байдлыг хэрэглэгчийн буюу өрхийн талаас болон үйлдвэрлэгч, импортлогчийн талаас судалж, онцгой албан татварын өнөөгийн байдлыг үнэлэх,

3. Архи, согтууруулах ундааны өөрийн болон солбицох үнийн мэдрэмжийг тодорхойлох,

4. Архи, согтууруулах ундааны татварыг тогтоох хувилбаруудыг харьцуулах, хүн амын эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийг судлах.

СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Судалгааг дараах үе шатаар зохион байгуулсан:

1. Архи, согтууруулах ундааны татварын бодлого хэрэгжүүлж буй улс орнуудын туршилгыг тоймлон судлах;

2. Хүн амын архи, согтууруулах ундааны хэрэглээг өрхийн түвшинд болон үйлдвэрлэл, импортын макро эдийн засгийн мэдээлэлд үндэслэн судлах;

3. Архи, согтууруулах ундааны нэрлэсэн болон бодит үнийг тодорхойлж, үнэд үзүүлэх онцгой татварын дарамтыг бүтээгдэхүүний нэр төрлөөр ялган судлах;

4. Архи, согтууруулах ундааны үнийн мэдрэмжийг Quadratic Almost Ideal Demand System (QAIDS) (Банкс, Бланделл, Левбел нар, 1997) ашиглан Өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгаа (ӨНЭЗТС)-ны үр дүнд суурилан тооцох (2018, 2019);

5. Тооцоолсон үнийн мэдрэмж, дотоодын үйлдвэрлэл, импортын мэдээллийг ашиглан архи, согтууруулах ундааны онцгой татвар хэлбэр, хэмжээний гурван хувилбараар бий болох татварын орлогыг тооцсон;

6. Архи, согтууруулах ундааны хэрэглээнээс үүдэлтэй голлох 5 өвчний статистик мэдээлэлд үндэслэн татварын хувилбар тус бүрээр эрүүл мэндийн дарамт хэрхэн өөрчлөгдөхийг судалсан.

Монгол улсын архи, согтууруулах ундааны зах зээлийн өнөөгийн байдлыг судлахад ашиглагдсан хэрэглэгдэхүүн

- Судалгаанд ашиглагдсан мэдээ, материалын найдвартай болон хүчин төгөлдөр байдлыг хангахын тулд бид хамгийн сүүлийн үеийн боломжит албан ёсны тоо мэдээллийг байгууллагаас эсвэл цахим хуудаснаас авч ашигласан.

Ашигласан тоо мэдээллийг эх сурвалжийн хамт доор жагсаав.

- Хэрэглээний үнийн индекс: архи, согтууруулах ундааны жижиглэнгийн үнийг тооцохдоо СҮХ-ны цаг хугацаа, хэрэглээний сагс дахь бараа, үйлчилгээний нэр төрлөөр ялган тодорхойлсон хэрэглээний үнийн индексийг ашигласан;

- Валютын ханш: Жилийн дундаж ханшийг тодорхойлохдоо Монгол Банкны зарласан сар тутмын ам. долларын ханшийг жилээр дундажлан тооцсон;

- Архи, согтууруулах ундааны зах зээлийн үнэ: СҮХ-ны гол нэрийн бүтээгдэхүүний хэрэглээний сагс дахь 2011-2020 оны үнэ болон 2017-2020 оны зах зээлийн үнийг худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн тайлан мэдээллээс авч ашигласан;

- Импортын мэдээлэл: Гаалийн ерөнхий газрын Статистикийн хэлстээс (ГЕГ-ын СХ) импортлосон архи, согтууруулах ундааны хэмжээ, гаалийн үнийн мэдээллийг тариф кодоор захиалан авч ашигласан;

- Дотоодын үйлдвэрлэлийн мэдээлэл: 2007-2020 онд дотоодод үйлдвэрлэсэн архи, согтууруулах ундааны хэмжээг Сангийн яамны Татварын орлогын хэлтсээс тус тус захиалан авч ашигласан.

Хүн амын архи, согтууруулах ундааны хэрэглээг баримтын судалгааны загвар ашиглан судалсан.

Архи, согтууруулах ундааны импортын болон дотоодын үйлдвэрлэлийн макро эдийн засгийн мэдээлэл (сүүлийн 20 жил) болон өрхийн хэрэглээний микро эдийн засгийн мэдээлэл (2018-2020)-ийг ашиглан дүн шинжилгээ хийлээ.

Архины үнэ болон борлуулалтын хамаарлыг судалсан аргачлал

Архины үнийн өөрчлөлт нь эрэлт болон нийлүүлэлтийг хэдий хэмжээтэй өөрчлөхийг судлах нь архины талаар баримтлах бодлогыг тодорхойлоход чухал нөлөөтэй юм. Үнийн өгөгдсөн түвшинд зах зээл дээр эрэлт болон нийлүүлэлт тэнцвэрждэг гэдэг эдийн засгийн онолд авч үздэг. Энэ утгаараа архины борлуулалтын орлогыг хэрэглэгч талаас харвал архины эрэлтийг Q^d илэрхийлэх бол үйлдвэрлэгч буюу борлуулагч талаас харвал нийлүүлэлтийн хэмжээ Q^s болж байна. Иймд эдийн засаг тэнцвэрт төлөвт байна гэвэл архины $Q^s = Q^d$ байна гэж үзнэ.

Судалгааг хийхэд архины үнийн мэдээлэл болон борлуулалтын мэдээлэлд үндэслэн архины үнээс хамаарсан борлуулалтын /эрэлт нийлүүлэлт тэнцүү гэвэл эрэлт гэж үзэж болно/ мэдээлэл шаардлагатай. Архины үнийн мэдээллийг судалгаанд ашиглахад хэд хэдэн эх үүсвэрээс авах боломжтой. Энэ хэсэгт ҮСХ-оос гаргадаг өргөн хэрэглээний барааны үнийн мэдээллээс Ерөөл архины үнийг авч судалгаанд ашиглалаа. Ингэхдээ бусад архины үнийн өөрчлөлт нь архинаас авах татвар, үйлдвэрлэлийн зардал болон түүхийн эдийн үнийн өсөлттэй уялдаад тодорхой хугацаанд ойролцоогоор ижил хувиар өөрчлөгддөг гэж таамаглав. Ерөөл архины хатуулгийн хэмжээ манайд одоо мөрдөж байгаа 25-аас 40 хувийн хатуулагтай архинд хамрагдах тул Сангийн яамнаас гаргадаг архины борлуулалтын мэдээллийг /25-аас 40 хувийн хатуулагтай/ ашиглан үнээс хамаарсан эрэлт /нийлүүлэлт/-ийн мэдрэмжийг тодорхойлов.

Судалгааны загварт үнэ 1 хувиар өөрчлөгдөхөд түүнээс хамаарч эрэлт дунджаар хэдэн хувиар өөрчлөгдөж байна вэ гэдгийг тодорхойлох шаардлагатай. Ийм шинж чанарыг илэрхийлдэг загвар нь логарифм загвар юм.

$$\ln dem_t = \beta_1 + \beta_2 \ln price_t + e_t$$

Онолын хувьд авч үзвэл үнэ өсөхөд эрэлт буурах ёстой. Өөрөөр хэлбэл үнэ 1 хувиар нэмэгдэхэд эрэлт $\beta_2 \beta_2$ хувиар буурах ёстой. Макро түвшинд эрэлт нийлүүлэлт тэнцүү гэдгээс нийлүүлэлтийн мэдрэмжийг давхар илэрхийлэх боломжтой бөгөөд хэрэв үнэ 1 хувиар нэмэгдвэл нийлүүлэлт $\beta_2 \beta_2$ хувиар нэмэгдэхийг илэрхийлнэ.

Архины үнэ /25-аас 40 хувийн хатуулагтай/ болон 1л архинд ногдох татварын хамаарлын шинжилгээний аргачлал

Дараагийн алхамд татвар хэдий хэмжээтэй нэмэгдэхэд үнэ хэдий хэмжээтэй өрчлөгдөж байна вэ гэдгийг тодорхойлох асуулт урган гарна. Энэ тохиолдолд 1л архинд ногдох татварыг 1 хувиар нэмэгдүүлэхэд үнэ хэдэн хувиар нэмэгдэж ирснийг түүхэн өгөгдөл ашиглан татвараас хамаарсан үнийн мэдрэмжийг тооцоох замаар тодорхойлъё.

Өмнө таамагласны дагуу архинд ногдуулж буй татвар хатуулгаас хамаараад ялгаатай боловч үнийн өсөлтийн хувь ижил байна гэсэн таамаглалын дагуу ногдуулж буй татварын өсөлтийг Ерөөл архины үнэтэй хамааралтай байдлаар загварчлан тодорхойллоо.

Загварын хувьд татвараас хамаарсан үнийн мэдрэмжийг тодорхойлж буй тул өмнөхтэй адил логарифм хэлбэрийн дараах загварыг ашиглав.

$$\ln price_t = \beta_1 + \beta_2 \ln tax_t + e_t$$

Мэдрэмжийн загварт тодорхойлогдож буй налалтын коэффициент болох $\beta_2 \beta_2$ нь 1 л архинд ногдох татвар 1 хувиар нэмэгдэхэд архины үнэ дунджаар $\beta_2 \beta_2$ хувиар нэмэгдэхийг харуулна. Таамаглалын хувьд $\beta_2 \beta_2$ коэффициент эерэг байна.

Өгөгдлийн хувьд ҮСХ-оос гаргасан Ерөөл архины үнэ мөн www.legalinfo.com сайт дээрх онцгой албан татварын хуульд буй 25-аас 40 хувийн хатуулагтай

архинд ногдуулах жил бүрийн татварын дүнг сард шилжүүлэн задлах байдлаар 2011 оны 1 сараас 2021 оны 6 сар хүртэлх нийт 126 сарын өгөгдлийг ашиглан загварыг үнэлэв.

Татварын өөрчлөлт нь тухайн авч үзэж буй архины үнэд нөлөөлөхөөс гадна түүний дараагийн хугацаанд дамжин нөлөөлөх боломжтой. Үүнийг загвар дахь хамааран хувьсагч болох архины үнэ нь тухайн хугацааны татварын хэмжээ болон түүний өмнөх хугацааны татварын хэмжээнээс хамаарч байгаа байдлаар тодорхойлсон.

Загварыг өмнөх хэсэгт авч үзсэнтэй адилаар логарифм загвараар Хамгийн бага квадратын аргыг ашиглан үнэлэхэд автокорреляцтай гарсан тул алдааны илэрхийллийн $ag(1)$ загварыг ашиглан Хамгийн үнэний хувь бүхий үнэлгээний аргаар засварлан үнэлсэн.

Архи, согтууруулах ундааны өөрийн болон солбицох үнийн мэдрэмжийг тооцсон аргачлал

Аж ахуйн нэгжийн үйл хөдлөлийг микро эдийн засгийн онолын үүднээс фирмийн онолоор судалдаг хэрэглэгч талаас нь хэрэглэгчийн үйл хөдлөлийн талаас нь судалдаг. Микро эдийн засагт хэрэглэгч бага зардлаар ханамжаа хамгийн их байлгах тийм хэрэглээг хангах зорилготой байх ба ханамжаа их байлгахын тулд өгөгдсөн төсвийн хүрээнд ханамжаа нэмэгдүүлэх янз бүрийн барааны хослолоос сонголтоо хийдэг. Энэ шинж чанарт тулгуурлан архины үнийн мэдрэмж болон солбилцох үнийн мэдрэмжийг архи согтуулах ундаа болон тамхины бүлэгт тулгуурлан Quadratic Almost Ideal Demand System (QAIDS) ашиглан тодорхойлохыг зорив.

ҮСХ-оос хэрэглээний үнийн индексийг тодорхойлоход ашиглагдаж буй арга зүйгээр архи, согтууруулах ундаа тамхи гэсэн бүлгийг ашигладаг. Энэ бүлэг нь шар айраг, дарс, архи виски, янжуур тамхи, дүнсэн тамхи гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Архи тамхины үнийн өөрчлөлтөөс гарах нөлөөг үнэ 1 хувийн өөрчлөгдөхөд эрэлт хэрхэн өөрчлөгдөх байдлыг өмнөх хэсгүүдэд тайлбарласан. Тодорхой бараа үйлчилгээний үнийн өөрчлөлт бусад орлуулах барааны эрэлтэд хэрхэн

нөлөөлөхийг солбицох үнийн мэдрэмжээр харуулдаг. Солбицох үнийн мэдрэмж нь тодорхой барааны үнэ 1 хувиар өөрчлөгдөхөд өөр нэг холбоотой барааны хэрэглээнд гарах өөрчлөлтийг хувиар илэрхийлдэг. Энэ хэсэгт дээр дурдсан QAIDS загварыг ашиглан архи согтууруулах ундаа тамхины үнийн болон солбисон үнийн мэдрэмжийг тооцохыг зорилоо.

Энэ системийн үнэлгээнд шар айраг, дарс, архи виски, янжуур тамхи, дүнсэн тамхи 5 хэсэг тус бүрдээр загвар үүсгэн систем тэгшитгэл хэлбэрээр тодорхойлсон загварыг үнэлсэн болно.

Энд загварын хамааран хувьсагчаар дээрх 5 төрлийн бүтээгдэхүүний архи, согтууруулах ундаа тамхи гэсэн бүлэг дотроо нэр төрөл тус бүрийн эзлэх хувийн жинг сонгон авсан бол тайлбарлагч хувьсагчаар тухайн барааны дундаж үнэ, борлуулагдсан тоо хэмжээ, өрхийн гишүүдийн дундаж тоо, өрхийн хэрэглээний хүнсний дундаж зарлага гэсэн хүчин зүйлийг сонгон авч үнэлгээг хийсэн.

Судалгаанд ҮСХ, Сангийн яам, Гаалийн ерөнхий газраас авсан 2010-аас 2020 он хүртэлх жил бүрийн өгөгдлийг ашиглав.

Загварыг EViews программ дээр систем объектыг үүсгэн үнэлгээг хийсэн.

Согтууруулах ундаанд татварыг ноогдуулах хувилбаруудыг харьцуулах замаар үр дүнг хүн амын эрүүл мэнд болон эрүүл мэндийн салбарын санхүүжилтэнд гарах байдлаар харьцуулсан хэсгийн аргачлал

Судалгааны энэ хэсэгт АСУ-нд онцгой албан татвар ноогдуулахад өргөн хэрэглэдэг үндсэн аргуудыг харьцуулан судлав.^{6,7} Манай улсын хувьд архи согтууруулах ундаанд ноогдуулах онцгой албан татварын хэмжээ нь бүтээгдэхүүний төрлөөс хамаарч 1 литр дутамд харилцан адилгүй байхаар

⁶ Holmes, John, et al. "Effects of minimum unit pricing for alcohol on different income and socioeconomic groups: a modelling study." *The Lancet* 383.9929 (2014): 1655-1664.

⁷ Meier, Petra S., et al. "Estimated effects of different alcohol taxation and price policies on health inequalities: a mathematical modelling study." *PLoS medicine* 13.2 (2016): e1001963.

хуульчилсан байна.⁸ Жишээ нь 25 хүртэл хатуулагтай бүх төрлийн цагаан архинд ноогдох татварын хэмжээ 3480 төгрөг, 25-40 градус хүртэл 6960 төгрөг, 40 ба түүнээс дээш бол 15660 төгрөг байхаар хуульчилсан байна. Эсрэгээрээ бүх төрлийн шар айрагт нэг литр тутамд 380 төгрөг байхаар тогтоосон байна. Энэхүү суурь татварын мэдээллийг ашиглан татвар ноогдуулах бусад аргууд болох нэгж хатуулагт ноогдуулах суурь үнэ, нэгж стандарт уултанд ноогдох суурь үнийг тус тус тооцоолж, харьцуулсан.

Бүтээгдэхүүний борлуулалтын үнийн мэдээлэл болон ОАТ-ын суурь түвшинг ашиглан нэгж хатуулагт ноогдуулах татвар болон стандарт уултаар тооцсон доод үнийг тогтоох аргуудыг тооцоход шаардлагатай суурь татварын хэмжээг тооцоолов. Ингэхдээ дараах аргуудыг харьцуулан судлав.

$\text{Борлуулалтын үнэ}_{\text{суурь түвшин}} = (\text{Татваргүй үнэ} + \text{ОАТ} + \text{НӨАТ})$ $\text{Борлуулалтын үнэ}_{\text{хатуулагт тооцсон}} = (\text{Татваргүй үнэ} + \text{ОАТ} \times \text{Бүтээгдэхүүний хатуулаг})$ $\text{Борлуулалтын үнэ}_{\text{стандарт уултаар тооцсон}} = (\text{Нэгж уултын үнэ} \times \text{Бүтээгдэхүүний уултын тоо})$

Согтууруулах ундааны төрөл нь бүтээгдэхүүний хатуулаг (градус) болон эзэлхүүн (савлагаа) хэмжээнээс хамаарч олон төрөлтэй байдаг. Олон төрлийн согтууруулах ундааны хэрэглээг “Стандарт уулт” хэмээх ухагдахуунаар жишиж үнэлдэг бөгөөд энэ нь нэгж тутамдаа 10 грамм этилийн спирт агуулах хэмжээгээр буюу архи, согтууруулах ундааны аль ч төрөлд найрлагандаа 10 грамм этилийн спирт агуулах хэмжээ нь 1 уулттай тэнцэнэ.⁹ Жишээ нь 330 мл нэг лааз 4-5% хатуулагтай шар айраг эсвэл 50мл хэмжээтэй 40% хатуулагтай цагаан архи нь нэг стандарт уулттай тэнцэнэ.

Судалгааны дараагийн алхамд бүтээгдэхүүний борлуулалтын үнэд эзлэх ОАТ-ын хэмжээг бусад улс орон болон олон улсын зөвлөмжид заасны дагуу нэмэгдүүлж үзэхэд борлуулалтын үнэ суурь үнэтэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдөхийг судлав. Ингэхдээ борлуулалтын үнэд эзлэх ОАТ-ын хэмжээг шар

⁸ Онцгой албан татварын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=434>

⁹ Miller WR, Heather N, Hall W. Calculating standard drink units: international comparisons. British journal of addiction. 1991 Jan;86(1):43-7.

айрганд 20%, 30%, 40% хүртэл хувь байхаар, цагаан архинд 40%, 50% болон 60% байх хувилбаруудыг тус тус тооцоолов.

Хүснэгт 1 Тооцоолол хийсэн алхам

#	Алхам	Тооцоолол
1.	Татвар нэмэх	<ul style="list-style-type: none"> Хатуулагт суурилсан татвар Стандарт уултанд суурилсан татвар Онцгой албан татвар
2.	Үнэ нэмэгдэх	<ul style="list-style-type: none"> Суурь үнэтэй харьцуулах Хувиар хэмжинэ.
3.	Хэрэглээг буурах	<p>Үнийн мэдрэмж:</p> $E_p = \frac{\Delta\% \text{ Тоо хэмжээний өөрчлөлт}}{\Delta\% \text{ Үнийн өөрчлөлт}}$
4.	Архидалтын эсрэг хөтөлбөрүүдийг харьцуулах	<ul style="list-style-type: none"> Татвар нэмэгдүүлэх Залуучуудад чиглэсэн хөтөлбөр Архи хэрэглэгч хүн ам (эмийн эмчилгээ)
5.	Архидалтын тархалт буурах	<ul style="list-style-type: none"> Динамик загвар Архины шалтгаант 5 оношийн бүлэг
6.	Хөтөлбөрийн үр дүнг тооцох	<ul style="list-style-type: none"> Сэргийлэх боломжтой архины шалтгаант өвчлөл Сэргийлэх боломжтой эрүүл мэндийн зардал

Татварын нөлөөгөөр борлуулалтын үнэ нэмэгдэхэд согтууруулах ундааны төрөл тус бүрд хэрэглээ хэрхэн өөрчлөгдөхийг үнийн мэдрэмжийн мэдээлэл ашиглан судлав. ДЭМБ-ын согтууруулах ундааны татвар тооцоолох аргачлалд дурьдсанаар бага, дунд орлоготой улс орнуудын хувьд бүтээгдэхүүний үнэ 10 хувиар нэмэгдэхэд шар айрагны хэрэглээ 5 хувиар харин цагаан архины хэрэглээ 8 хувиар тус тус буурдаг гэсэн мэдээллийг ашиглав.¹⁰

¹⁰ Sornpaisarn, B., Shield, K. D., Österberg, E., & Rehm, J. (2017). Resource tool on alcohol taxation and pricing policies.

Үнэ нэмэгдэж хэрэглээ буурах нөлөөг согтууруулах ундааны 3 төрлийн хэрэглээний түвшинд хэрхэн нөлөөлж буйгаар судлав. Ингэхдээ нийт хүн амыг архи хэрэглэх эрсдэлээс хамааруулаад ДЭМБ-аас гаргасан эрсдэлийн зэрэгт хуваав. Үүнд

- Өндөр эрсдэлтэй хэрэглэгч: Эрэгтэй хүн ≥ 60 г, эмэгтэй хүн ≥ 40 г
- Дунд зэргийн эрсдэлтэй хэрэглэгч: Эрэгтэй: 40-59.9 г, эмэгтэй: 20-39.9 г
- Бага эрсдэлтэй хэрэглэгч: Эрэгтэй хүн < 40 г, эмэгтэй хүн < 20 г

Архины хэрэглээг бууруулах үр дүнтэй хөтөлбөрийг сонгох, зохисгүй хэрэглээг хянах зорилгоор улс орнууд олон янзын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Оновчтой хөтөлбөрийг сонгох, хэрэгжүүлэх хүрээг тодорхойлох, зорилтод хүн ам болон насны бүлгүүдийг зөв тодорхойлох нь хамгийн чухал алхам байдаг. Иймээс улс орнуудад дэмжлэг үзүүлэх зориогоор ДЭМБ-аас SAFER багц хөтөлбөрүүдийг улс орнуудад санал болгосон байна.¹¹ (Хүснэгт 3)

Хүснэгт 2 Харьцуулалт хийсэн хөтөлбөрүүд

Хөтөлбөрүүд		Насны бүлэг	Тайлбар
Өнөөгийн нөхцөл байдал цаашид хэвээр			
Татвар нэмэх	• ОАТ хэмжээг 40% хүргэх	15-64 нас	Согтууруулах ундааны борлуулалтын үнэд эзлэх ОАТ-ын хэмжээг бусад улс оронтой ижил түвшинд хүргэх хөтөлбөр
	• ОАТ хэмжээг 50% хүргэх		
	• ОАТ хэмжээг 60% хүргэх		
Залууст чиглэсэн хөтөлбөр		18-30 нас	Сургууль орчмын архины худалдааг хориглох, залуучуудад чиглэсэн хөтөлбөр
Архи хэрэглэдэг бүлэгт чиглэсэн хөтөлбөр		40-өөс дээш нас	Эмчиглгээ, оношлогоог сайжруулах хөтөлбөр

¹¹ World Health Organization. "The SAFER technical package: five areas of intervention at national and subnational levels." (2019).

Хүн амын динамик өсөлттэй уялдуулан нийт хүн амын тоо, нийт нас баралт болон төрөлтийн тоо мэдээллийг марков загварчлал ашиглан урт хугацаанд гарах өөрчлөлтийг өмнө хийсэн хэвлэгдэсэн судалгааны аргачлалын дагуу судлав^{12,13}.

Ингэхдээ хүн амыг архины хэрэглээний тархалтын түвшингээр нь задлаж, зонхилон тохиолддог, архинд хамааралтай оношийн 5 бүлгийн өвчлөл, тархалт болон нас баралтын тоо мэдээлэлтэй холбож, ирээдүйн хандлага, тархалтанд гарах өөрчлөлтийг харьцуулан судлав.

Хөтөлбөрийн үр дүнг аврагдсан буюу сэргийлэх боломжтой архи эрсдэлтэй хэмжээгээр хэрэглэгчийн тоо, сэргийлэх боломжтой архины шалтгаант өвчлөлийн тархалтын тоо, сэргийлэх боломжтой нас баралтын тоо, аврагдсан хөдөлмөрийн чадвар алдалтаар тооцсон жилийн хэмжээ болон хэмнэх боломжтой эрүүл мэндийн санхүүжилтын хэмжээ зэрэг мэдээллээр тооцож, эрэмбэлэв.

Хөтөлбөрийн үр дүнг богино хугацаанд 3 жилийн дотор аврагдах боломжтой архи хэтрүүлэн хэрэглэдэг хүн амын тоогоор тооцож, урт хугацаанд буюу 30 жилийн хугацаанд аврагдах боломжтой өвчлөл болон санхүүжилтын хэмжээг тооцож, өнөөгийн үнэ цэнийг жилийн 3% байхаар судлав. Санхүүжилтын хэмжээг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлж буй өртөг ойролцоо оношийн бүлгийн санхүүжилтийн хэмжээгээр тооцож, хэмнэсэн зардлын хэмжээг тооцов.

Судалгаанд ашигласан тоо мэдээллийн төрөл, түүний эх үүсвэрийг дараах хүснэгтээр харуулав. хүн амзүй тоо мэдээллийг ҮСХ-оос, архины шалтгаант өвчлөл, нас баралтын мэдээллийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бүртгэл мэдээллээс, санхүүжилтийн хэмжээг ЭМД-ын санхүүжилтийн байдлаар тус тус цуглуулав. Архины хамааралтай оношийн бүлэгт хамаатуулах эрсдлийн мэдээлэл

¹² Lhachimi, Stefan K., et al. "Health impacts of increasing alcohol prices in the European Union: a dynamic projection." *Preventive medicine* 55.3 (2012): 237-243.

¹³ Tuvdendorj A, Konings SR, Purevdorj B, Buskens E, Feenstra TL. Reducing the Burden of Disease Through Tobacco Taxes in Mongolia: A Health Impact Analysis Using a Dynamic Public Health Model. *Nicotine and Tobacco Research*. 2022 Feb;24(2):233-40.

болон хамаатуулах хөдөлмөрийн чадвар алдалтын тоо мэдээллийг бусад улс орны судалгаанаас цуглуулав.

Хүснэгт 3 Ашигласан мэдээ материал

	Төрөл	Тоо мэдээлэл	Эх үүсвэр
1.	Хүн амзүйн мэдээлэл	<ul style="list-style-type: none"> • Нийт хүн амын тоо • Төрөлтийн тоо • Нийт нас баралтын тоо 	Үндэсний статистикийн хороо
2.	Архины тархалтын мэдээлэл	<ul style="list-style-type: none"> • Архи удаггүй бүлэг • Бага эрсдэлтэй уудаг бүлэг • Дунд эрсдэлтэй уудаг бүлэг • Өндөр эрсдэлтэй уудаг бүлэг 	ХБӨ-ний үндэсний судалгаа- 2019
3.	Архины шалтгаант өвчлөл	<ul style="list-style-type: none"> • Уруул амны өмөн C00-C14 • Улаанхоолойн өмөн-C15 • Элэгний өмөн– C22 • Цочмог панкреатит- K85 • Элэгний цирроз - K74 	Эрүүл мэндийн хөгжлийн төв. Хүн амын өвчлөлийн мэдээлэл, 2021
4.	Архины хамаатуулах эрсдэл	<p>Жишээ K75 оношийн хувьд</p> <ul style="list-style-type: none"> • RR=1 • RR=1.23 • RR=1.7 • RR=3.5 	Судалгаа
5.	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь	<ul style="list-style-type: none"> • C00-C14 = 63 • C15= 59 • C22= 76 • K85=68 • K74=85 	Судалгаа
6.	Оношийн бүлэгт хамаатуулах зардал	Оношийн бүлгээс хамаарч 600 мянгаас 2.6 сая хүртэл төгрөг зарцуулдаг	Эрүүл мэндийн даатгалын сангийн мэдээлэл


СУДАЛГААНЫ ҮР ДҮН

МОНГОЛ УЛС ДАХЬ АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ, ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хүн амын архи, согтууруулах ундааны хэрэглээ, хүртээмж

Монгол улсын хүн амын халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн сүүлийн гурван удаагийн судалгаа (2009-2019 он)-ны үр дүнгээр сүүлийн нэг сарын хугацаанд архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын эзлэх хувьд төдийлөн өөрчлөлт ороогүй буюу 2009 онд 38.6%, 2013 онд 36.3%, 2019 онд 35% байжээ. Сүүлийн нэг сарын хугацаанд архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын нэг удаад уусан хэмжээг харьцуулахад 2009-2019 онд 7.7 уултаас 9.3 уулт болж нэмэгдсэн байна.

Монгол улсад дотооддоо үйлдвэрлэсэн болон импортлосон архи, согтууруулах ундааны жилийн бодит утгыг тухайн оны нийт хүн хүн амын тоотой харьцуулан нэг хүнд ногдох архи, согтууруулах ундааны хэмжээг тодорхойлоход, 2020 онд нэг хүнд архи 7.2 л, шар айраг 25.5 л, дарс 0.1 л тус тус ногдож байна. Үүнээс нэг хүнд ногдох шар айрагны хэмжээ 2008 онд 14.7 литр байснаа 2020 онд 25.5 литр болж 1.7 дахин буюу хамгийн их хэмжээгээр нэмэгдсэн байна.




Зураг 1 Нийт хүн амаас жилд нэг хүнд ногдох архи, согтууруулах ундааны хэмжээ, литрээр, нэр төрлөөр, 2008-2020 он

Нэг хүнд ногдох нийт архи, согтууруулах ундааны хэмжээ 2008 онд 24 л байснаа 2020 онд 36 л болж 1.5 дахин нэмэгдсэн байна.

Монгол улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7.3.2-ын 21 нас хүрээгүй хүнд архи, согтууруулах ундаагаар үйлчлэхийг хориглох тухай заалтыг үндэслэн 21-ээс дээш настай нэг хүнд ногдох архи, согтууруулах ундааны хэмжээг тооцоход 2020 оны байдлаар шар айрагны хэмжээ 42 л, архины хэмжээ 12 л болж 2008 оноос 1.7 дахин нэмэгдсэн, харин архи, дарсны хэмжээнд төдийлөн өөрчлөлт гараагүй байна.

Өмнөх 5 жилтэй харьцуулахад 2020 онд архи, шар айраг, дарсны нэг хүнд ногдох хэмжээ бага зэрэг буурсан үзүүлэлттэй байгаад тухайн онд КОВИД-19 халдварын цартахлын улмаас бүх нийтийг хамарсан болон хэсэгчилсэн хөл хориог улсын хэмжээнд болон аймаг, орон нутгийн хэмжээнд тогтоосон, бүх нийтийг хамарсан баяр ёслолын үйл ажиллагааг тэмдэглээгүй зэрэг цаг үеийн үйл явдлууд нөлөөлсөн байж болох талтай.



Зураг 2 21-ээс дээш настай нэг хүнд 1 жилд ногдох архи, согтууруулах ундааны хэмжээ, литрээр, нэр төрлөөр, 2008-2020 он

Архи, согтууруулах ундаа жижиглэнгээр худалдаалдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоог үйлчилгээний төрлөөр судалж үзэхэд аймаг, орон нутгийн хэмжээнд том, дунд оврын дэлгүүр 185, багавтар хэмжээтэй дэлгүүр 644, бага хэмжээтэй хүнсний мухлаг 3638 байгаа бол Улаанбаатар хотод том, дунд

оврын хайпермаркет, супермаркет 175, багавтар буюу минимаркет 754, бага буюу хүнсний дэлгүүр, мухлаг 6332 бүртгэлтэй байна.¹⁴

Улсын хэмжээнд, 2020 оны жилийн эцсийн байдлаар хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт нийтдээ 8500 орчим аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагийн 47% нь аймаг орон нутагт, 53% нь нийслэл хотод ажиллаж байна. Үүнээс ресторан 1570, кафе 400, баар 1331 тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байна. Улсын хэмжээнд 3200 гаруй нь архи согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөлтэй байна.¹⁵

Доорх хүснэгтээр Монгол улсад архи, согтууруулах ундаа жижиглэнгээр худалдаалж, түүгээр үйлчилж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоог хот, хөдөөгөөр ангилан, 21-ээс дээш настай иргэдийн тоонд харьцуулан нэг цэгт ногдох иргэний тоог харуулав.

Хүснэгт 4 Архи, согтууруулах ундаа жижиглэнгээр худалдаалж, үйлчилж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо, нэг цэгт ногдох 21-ээс дээш настай хүн амын тоо

Байрлал	Архи, согтууруулах ундаа жижиглэнгээр худалдаалдаг, үйлчилдэг газрын тоо	Нэг үйлчилгээний газарт оногдох 21-ээс дээш настай хүн амын тоо
Аймаг, орон нутаг	5523	192
Улаанбаатар	9452	97
Нийт	14975	132

Монгол улсын хэмжээнд архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг, жижиглэн худалдаалдаг бүртгэлтэй цэг нийт 14975 байгаагийн дийлэнх хувь буюу 63% нь Улаанбаатар хотод байрлалтай байна. Архи, согтууруулах ундаагаар үйлчлэх нэг цэгт аймаг орон нутагт 21-ээс дээш настай 192 иргэн, Улаанбаатар хотод 97, улсын хэмжээнд 132 иргэн ногдож байна.

¹⁴ ХХААХҮЯ. Дотоод худалдааны салбарын танилцуулга, 2020 он (<https://mofa.gov.mn/exp/blog/10/181>)

¹⁵ ХХААХҮЯ. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын танилцуулга, 2020 он (<https://mofa.gov.mn/exp/blog/10/85>)

Хүснэгт 5 21-ээс дээш настай 10000 хүн амд ногдох их эмч, эрүүл мэндийн байгууллага, архи согтууруулах ундаагаар үйлчлэх цэгийн тоо

Байрлал	21-ээс дээш настай 10000 хүн амд ногдох их эмчийн тоо	21-ээс дээш настай 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн байгууллагын тоо	21-ээс дээш настай 10000 хүн амд ногдох архи согтууруулах ундаагаар үйлчлэх цэгийн тоо
Аймаг, орон нутаг	44	17	52
Улаанбаатар	85	30	103
Улсын дүн	63	23	76

Архи, согтууруулах ундаагаар үйлчлэх цэгийн хүртээмжийг хүн ам үзүүлж буй эрүүл мэндийн тусламжийн хүртээмжийн зарим үзүүлэлттэй харьцуулан дээрх хүснэгтэд харуулав. Архи, согтууруулах ундаагаар үйлчлэх цэгийн хүртээмж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжээс илүү байна. Тухайлбал, улсын хэмжээнд 21-ээс дээш настай 10000 хүн ам тутамд ногдох их эмчийн тоо 63, эрүүл мэндийн байгууллагын тоо 23 байгаа бол архи согтууруулах ундаагаар үйлчлэх цэгийн тоо 76 байна.

Архи, согтууруулах ундааны зах зээлийн өнөөгийн байдал

Архи, согтууруулах ундаа нь эдийн засгийн үйл ажиллагааны ангиллын дагуу “ундаа үйлдвэрлэл” салбарт хамрагддаг бөгөөд тус салбарын үйлдвэрлэл 2020 онд 752 тэрбум төгрөгт хүрч, 2008 оноос 4 дахин, борлуулалт 538 тэрбум төгрөгт хүрч, 2008 оноос 4 дахин нэмэгдсэн байна. Харин аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл болон борлуулалтад ундаа үйлдвэрлэлийн эзлэх хувь буюу бүтцийг авч үзвэл өөрчлөлт бага, 2008-2020 онд дунджаар нийт үйлдвэрлэлийн 4.5 хувь, борлуулалтын 5.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 6 Монгол улс дахь ундаа үйлдвэрлэл, аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, борлуулалт, 2008-2020 он, тэрбум төгрөгөөр

Он	Нийт үйлдвэрлэл	Үүнээс		Нийт борлуулалт	Үүнээс	
		Ундаа үйлдвэрлэл	Нийт үйлдвэрлэлд эзлэх хувь		Ундаа үйлдвэрлэл	Нийт борлуулалтад эзлэх хувь
2008	3461.3	169.7	4.9	2877.3	144.4	5
2009	3594.5	163.2	4.5	3073.5	175.8	5.7
2010	6481.3	289.3	4.5	4456.1	275.8	6.2
2011	8777.3	467.4	5.3	5596.5	375.5	6.7
2012	9821.3	553.3	5.6	6224.1	470.2	7.6
2013	10443.7	512.8	4.9	6661.1	445.6	6.7
2014	14402.9	676.6	4.7	11108	514.1	4.6
2015	14803.2	642.5	4.3	9998.1	527	5.3
2016	15663.8	653.8	4.2	11067	605	5.5
2017	20650.4	671	3.2	15160.7	740.9	4.9
2018	17443.9	744.3	4.3	18297.5	828.2	4.5
2019	17998	686.9	3.8	20101.8	1017.2	5.1
2020	17115.8	752.5	4.4	7073.8	538.9	7.6

Монгол улс дахь архи, согтууруулах ундааны үйлдвэрлэлийн нийт биет хэмжээ 2020 онд 120.5 сая литр болж, 2007 оноос 3 дахин нэмэгдэхэд шар айргийн үйлдвэрлэл 4.4 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Архины үйлдвэрлэлийн хэмжээ 1.4 дахин, спирт үйлдвэрлэлийн хэмжээ 1.1 дахин нэмэгдсэн бол дарсны үйлдвэрлэлийн хэмжээ 30 хувиар буурсан байна.

Хүснэгт 7 Архи, согтуулах ундааны дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ, 2007-2020 он, мянган литрээр

Он	Спирт	Архи	Дарс	Шар айраг	Нийт
2007	-	17,181.75	351.78	19,316.60	36,850
2008	-	22,207.61	360.72	28,675.60	51,244
2009	-	16,572.74	205.74	27,875.73	44,654
2010	-	21,175.57	331.52	43,831.88	65,339
2011	-	27,261.97	218.82	60,157.36	87,638
2012	-	27,709.22	191.60	65,644.80	93,546
2013	-	24,338.09	16,706.97	55,628.99	96,673
2014	9182.202	24,128.46	263.84	81,107.97	114,683
2015	7819.37	19,526.10	194.88	71,318.05	98,858
2016	9280.082	23,627.80	158.38	76,606.25	109,673
2017	9830.287	25,088.01	252.88	83,497.95	118,669
2018	10743.28	26,818.18	208.88	88,152.03	125,922
2019	10542.23	27,092.55	296.00	85,928.40	123,859
2020	10574.53	24,265.03	245.50	85,451.88	120,537

Импортоор оруулсан архи, согтууруулах ундааны төрлийн бүтээгдэхүүний хэмжээ 2020 онд 9 сая литр болж 2008 он оос 2.6 дахин буурчээ. Үүнд шар айргийн хэмжээ дурдсан хугацаанд 3 дахин буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин архи, вискиний төрлийн бүтээгдэхүүний хэмжээ 3 дахин, дарсны төрлийн бүтээгдэхүүний хэмжээ 20 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 8 Архи, согтууруулах ундааны импортын хэмжээ, 2008-2020 он, сая литр


	Архи	Дарс	Шар айраг	Нийт
2008	242	2,677	20,469	23,388
2009	162	1,341	10,630	12,133
2010	208	2,347	18,848	21,403
2011	598	3,431	21,943	25,972
2012	798	3,486	28,675	32,961
2013	604	2,480	33,208	36,292
2014	718	2,594	21,676	24,989
2015	620	2,189	15,861	18,671
2016	1,044	1,982	16,685	19,711
2017	1,281	2,638	6,386	10,305
2018	561	2,458	7,231	10,251
2019	611	2,318	5,047	7,976
2020	647	2,121	6,220	8,988

Монгол улсын зах зээлд нийлүүлэгдэж байгаа нийт архи, согтууруулах ундааны дийлэнх хувийг буюу 93%-ийг дотоодын бүтээгдэхүүн эзэлж байна. Нэр, төрлөөр нь авч үзвэл, дотоодод үйлдвэрлэсэн архи зах зээлийн 97%, импортын дарс 89.6%, дотоодод үйлдвэрлэсэн шар айраг 93%-ийг тус тус эзэлж байна.

Архи, согтууруулах ундааны үнэ, онцгой татварын үнэлгээ


Монгол улсад архи, согтууруулах ундаанд онцгой татвар 2007 оноос хойш ногдуулж эхэлсэн. Бүх төрлийн 40 хүртэлх хатуулагтай цагаан архинд 2010 оныг хүртэл 1 литр тутамд 2 ам долларын онцгой татвар ногдуулж байсан ба цаашид онцгой татварыг төгрөгөөр ногдуулж эхэлсэн байна. Дотоодод үйлдвэрлэсэн цагаан архины 1 литр тутам дахь онцгой татварын хэмжээ 2007 онд 2330 төгрөг байсан бол 2020 онд 6960 төгрөг болж 3 дахин нэмэгдсэн, харин түүнээс үүсэх

онцгой татварын жилийн орлого 3 тэрбум төгрөгөөс 162 тэрбум төгрөгт хүрсэн байна.



Зураг 4 Дотоодын 1 л цагаан архинд ногдуулсан онцгой татварын хэмжээ ба онцгой татварын жилийн орлого, 2007-2020


Харин дотоодод үйлдвэрлэсэн шар айрагны нэг литр тутамд ногдох онцгой албан татварын хэмжээ 2011 онд 253 төгрөг байсан бол 2020 онд 350 төгрөг болж 1.4 дахин нэмэгдсэн байна. Дотоодын үйлдвэрийн шар айрагнаас олж буй онцгой татварын орлого 15 тэрбум төгрөгөөс 30 тэрбум төгрөг болж 2 дахин нэмэгджээ.



Зураг 3 Нэг литр шар айрагт ноогдох онцгой албан татвар, төрлөөр

Дотоодод үйлдвэрлэсэн цагаан архи, шар айрагны үнэнд шингэсэн НӨАТ болон онцгой татварын хэмжээг ялгаж, нэрлэсэн үнэ болон хэрэглээний хамаарлыг доорх графикаар харуулав.


Дотоодын зах зээлд борлуулагдсан дотоодын үйлдвэрийн цагаан архины нэрлэсэн үнэ нь 2007-2020 онд нэг литр тутамд 6128 төгрөгөөс 17635 төгрөг болж бараг 3 дахин өссөн боловч дотоодын зах зээлд борлуулагдсан архины хэмжээ 16 сая литрээс 23.3 сая литр болж 1.4 дахин нэмэгдсэн бөгөөд борлуулалтын хэмжээ жил ирэх тусам өсөх хандлагатай байна.



Зураг 4 Дотоодын үйлдвэрийн 1 л цагаан архины үнэ ба жилийн борлуулалтын хэмжээ, 2007-2020 он


Харин дотоодын зах зээлд борлуулагдсан дотоодын үйлдвэрийн шар айрагны нэрлэсэн үнэ нь 2011-2020 онд нэг литр тутамд дунджаар 2155 төгрөгөөс 3579 төгрөг болж 1.7 дахин өссөн, дотоодын зах зээлд борлуулагдсан шар айрагны хэмжээ 2011-2020 онд 60 сая литрээс 87.7 сая литр болж 1.5 дахин нэмэгдсэн бөгөөд борлуулалтын хэмжээ жил ирэх тусам өсөх хандлагатай байна.

Дотоодын үйлдвэрийн цагаан архины нэрлэсэн үнэд эзлэх онцгой татварын хувь хэмжээг тооцож үзэхэд 2007 онд 38% байсан бол 2020 онд 39.5% байгаа, дотоодын үйлдвэрийн шар айрагны хувьд 2011 онд 11%, 2020 онд 9.8% байгаа нь архи, согтууруулах ундаанд онцгой татвар ногдуулах болсон өнгөрсөн 13 жилийн хугацаанд бүтээгдэхүүний үнэд эзлэх татварын хэмжээнд тодорхой өөрчлөлт гараагүй болохыг илтгэж байна.




Зураг 5 Дотоодын үйлдвэрийн 1 л шар айрагны үнэ ба жилийн борлуулалтын хэмжээ, 2011-2020 он

Нөгөө талаас, архи, согтууруулах ундааны өнөөг хүртэлх үнийн өөрчлөлт нь хэрэглээнд бодитоор нөлөөлж чадахгүй байгааг харж болно. Иймд дотоодын үйлдвэрийн цагаан архи, шар айрагны нэрлэсэн үнэ болон бодит үнийг 2011-2020 оны хэрэглээний сагсны үнэ, хэрэглээний үнийн индексийг ашиглаж бүтээгдэхүүний нэр төрлөөр судлан харьцуулав.



Зураг 8 Дотоодын архины нэрлэсэн болон бодит үнэ, төгрөгөөр, 2011 оны 1 сараас 2020 оны 12 сар

Эндээс, хэдийгээр дотоодын цагаан архины 1 литр тутамд ногдох нэрлэсэн үнэ 2011 оноос хойш 8900 төгрөгөөс аажим өссөөр 2020 оны 12 сард 17750 төгрөг болж нэмэгдсэн боловч инфляцийн нөлөөллийг хянаж тооцсон бодит үнэд төдийлөн өөрчлөлт гараагүй, буюу хугацааны эхэнд бодит үнэ 13650 төгрөг, төгсөлд 14537 төгрөг, дунджаар 14813 төгрөг байна.



Зураг 9 Дотоодын үйлдвэрийн шар айрагны нэрлэсэн болон бодит үнэ, төгрөгөөр, 2011 оны 1 сараас 2020 оны 12 сар

Шар айрагны хувьд ч мөн адил дүр зураг харагдаж байна. Нэг литр тутамд ногдох нэрлэсэн үнэ 2011 оноос хойш 2155 төгрөгөөс аажим өссөөр 2020 оны 12 сард 3579 төгрөг болж нэмэгдсэн боловч инфляцийн нөлөөллийг хянаж тооцсон бодит үнэд төдийлөн өөрчлөлт гараагүй, буюу хугацааны эхэнд бодит үнэ 3238 төгрөг, төгсөлд 2962 төгрөг, дунджаар 14813 төгрөг байна.

Өөрөөр хэлбэл, өнгөрсөн хугацаанд архи, согтууруулах ундаанд ногдуулсан онцгой татвар нь үнийг бодитоор өсгөж, худалдан авалтыг бууруулахад биш, харин инфляцийн түвшинг тусгахад чиглэсэн болохыг харах боломжтой байна.

Бүлгийн дүгнэлт

1. Архи, согтууруулах ундаанд онцгой албан татвар ногдуулж эхэлснээс хойш хэрэглээ хувь хүн, өрхийн болон улс орны түвшинд буураагүй байна.
2. Монгол улсад архи, согтууруулах ундаа жижиглэнгээр худалдаалж, түүгээр үйлчилж байгаа аж ахуйн нэг нэгжид 21-ээс дээш настай 132 (Улаанбаатар хотод 97, аймаг, орон нутагт 192) иргэн ногдож байна.
3. Монгол улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7.3.2-ын 21 нас хүрээгүй хүнд архи, согтууруулах ундаагаар үйлчлэхийг хориглох тухай заалтыг үндэслэн 21-ээс дээш настай нэг хүнд ногдох архи, согтууруулах ундааны хэмжээг тооцоход 2008 онтой харьцуулахад 2020 онд архи, дарсны хэмжээ төдийлөн өөрчлөгдөөгүй, харин шар айрагны хэмжээ 1.7 дахин нэмэгдсэн байна.
4. Монгол улсын зах зээлд нийлүүлэгдэж байгаа нийт архи, согтууруулах ундааны дийлэнх хувийг буюу 93%-ийг дотоодын бүтээгдэхүүн эзэлж байна. Нэр, төрлөөр нь авч үзвэл, дотоодод үйлдвэрлэсэн архи зах зээлийн 97%, импортын дарс 89.6%, дотоодод үйлдвэрлэсэн шар айраг 93%-ийг тус тус эзэлж байна.
5. Дотоодын зах зээлд борлуулагдсан дотоодын үйлдвэрийн цагаан архины нэрлэсэн үнэ нь 2007-2020 онд нэг литр тутамд 6128 төгрөгөөс 17635 төгрөг болж бараг 3 дахин өссөн боловч дотоодын зах зээлд борлуулагдсан архины хэмжээ 16 сая литрээс 23.3 сая литр болж 1.4 дахин нэмэгдсэн байна. Цаашид борлуулалтын хэмжээ жил ирэх тусам тогтвортой өсөх хандлагатай, түүнийг дагалдан

үйлдвэрлэгчийн ашиг болон онцгой албан татвараас орох улсын төсвийн орлого нэмэгдсээр байна.

6. Дотоодын үйлдвэрийн цагаан архины нэрлэсэн үнэд эзлэх онцгой татварын хувь хэмжээг 2007 онд 38% байсан бол 2020 онд 39.5%, шар айрагны хувьд 2011 онд 11%, 2020 онд 9.8% байгаа нь архи, согтууруулах ундаанд онцгой татвар ногдуулах болсон өнгөрсөн 13 жилийн хугацаанд бүтээгдэхүүний үнэд эзлэх татварын хэмжээнд тодорхой өөрчлөлт гараагүй болохыг илтгэж байна.

7. Архи, согтууруулах ундаанд ногдуулсан онцгой татвар нь үнийг бодитоор өсгөж, худалдан авалтыг бууруулахад биш, харин инфляцийн түвшинг тусгахад чиглэсэн байна.

8. Архи, согтууруулах ундаанд агуулагдах цэвэр спиртийн агууламжид татвар ногдуулснаар өндөр хатуулагтай согтууруулах ундааны хэрэглээг хүн амын дунд бууруулах боломжтой.

АРХИНЫ ҮНЭ, ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН МЭДРЭМЖИЙГ СУДАЛСАН ҮР ДҮН

Эдийн засгийн онолын үүднээс авч үзвэл үнэ өсөхөд эрэлт буурдаг, нийлүүлэлт талаасаа үнэ өсөх нь борлуулалтыг нэмэгдүүлдэг. Үнэ хэдий хэмжээтэй өөрчлөгдөхөд эрэлт эсвэл нийлүүлэлт хэдий хэмжээтэй өөрчлөгдөхийг мэдэх нь бизнесийн түвшинд аж ахуйн нэгж, байгууллага, макро түвшинд бодлого боловсруулагчид цаашид үйлдвэрлэлийн хэмжээ болон орлогын талаар баримтлах стратегиа тодорхойлох чухал суурь болдог. Энэхүү үнийн өөрчлөлтөөс шалтгаалан эрэлт эсвэл нийлүүлэлт хэдий хэмжээтэй өөрчлөгдөхийг тодорхойлох нэг чухал үзүүлэлт нь мэдрэмж юм. Нэг үзүүлэлтийн /хувьсагч/ өөрчлөлтийн нөлөөгөөр нөгөө хэмжигдэхүүн хэдий хэмжээтэй өөрчлөгдөж байгааг мэдрэмж харуулдаг.

Архины үнэ болон борлуулалтын хамаарал

Өгөгдлийн хувьд архины борлуулалтыг 25-аас 40 хувь хүртэлх хатуулагтай гэж ялгасан дүнгээр авах боломжтой 2014 оны 1 сараас 2021 оны 6 сар хүртэлх нийт 90 сарын сар бүрийн архины борлуулалтын мэдээ болон мөн хугацааны Ерөөл архины үнийн мэдээллийг ашиглалаа. Загварын шаардлагаас үүдэн хувьсагч тус бүрээс натурал логарифм авч Хамгийн бага квадратын аргаар үнэлгээг дараах байдлаар хийв.

$$\ln \text{supp}_t = 9.89 + 1.54 \ln \text{price}_t$$

[2.58] [3.62]

Үнэлгээний үр дүнгээс харвал тухайн сард архины үнэ 1 хувиар нэмэгдэхэд эрэлт /нийлүүлэлт/ дунджаар 1.54 хувиар нэмэгдэж байна. Нийлүүлэлтийн мэдрэмж гэдэг талаасаа авбал үнэ 1 хувиар нэмэгдэж байгаа тохиолдолд орлого 1-ээс өндөр хувиар давж байгаа тул мэдрэмж сайтай бүтээгдэхүүн байна. /Хавсралт хүснэгт 1./

Загварын хувьд мэдрэмжийн коэффициент болох β_2 нь 1 хувийн түвшинд статистик ач холбогдолтой, автокорреляцгүй, шалтгааны нөхцөл байдлыг тодорхойлдог Гранжерийн шалгуураар үнэ нь эрэлт /нийлүүлэлт/-д нөлөөлдөггүй гэсэн таамаглал 5 хувийн түвшинд няцаагдаж нөлөөлдөг гэдгийг хүлээн

зөвшөөрсөн бөгөөд эсрэгээрээ эрэлт /нийлүүлэлт/ нь үнэд нөлөөлдөггүй гэсэн таамаглалыг хүлээн зөвшөөрөгдөж байна.

Энэ нь татварыг нэмэгдүүлэх замаар архины үнийг өсгөсөн тохиолдолд архины борлуулалтаас орох татварын орлого нэмэгдэхээр харагдаж байна.

Загварын үр дүнг ашиглан архины үнийг хамгийн сүүлд 2021 оны 6 сард 9109 төгрөг байх үед 24.4 орчим тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой байсан ба архины үнийг 10%, 20%, 30%, 40%, 50% нэмэгдүүлэхэд борлуулалтын орлого ямар хэмжээтэй өөрчлөгдөх вэ гэдэг симуляцийг хийж үзье.

Хүснэгт 9 Архины үнийн өөрчлөлт ба борлуулалтын орлогын өсөлтийн симуляц

Архины үнэ	Архины үнийн өсөлт	Борлуулалтын орлого, төгрөгөөр	Борлуулалтын орлогын өсөлт, төгрөгөөр
(1)	(2)	(3)	(4)
9109.0	0	24,350,350,092.0	-
10019.9	10%	29,681,679,356.8	21.89
10930.8	20%	33,949,212,083.0	14.38
11841.7	30%	38,414,786,913.9	13.15
12752.6	40%	43,071,293,109.4	12.12
13663.5	50%	47,912,376,373.1	11.24

Хүснэгтээс харвал үнэ нэмэгдэхэд борлуулалтын орлого /3-р багана/ нэмэгдэж байгаа ч борлуулалтын орлогын өсөлт /4-р багана/ саарч байгаа нь харагдаж байна.

Архины үнэ өсөхөд борлуулалт яагаад нэмэгдээд байна вэ? Эдийн засгийн эрэлт нийлүүлэлтийн хуулиар үнэ өсөхөд эрэлт буурдаг гэж үздэг. Гэтэл манай улсын нөхцөл байдлаас харвал үнэ өсөхөд борлуулалтын орлого нэмэгдэж байна гэсэн үр дүнд хүрч байна. Үүний гол шалтгаан нь өрхийн орлогын өсөлтийн хурдыг

архины үнийн өсөлтийн хурд гүйцэхгүй байгаатай холбон тайлбарлах шаардлагатай гэж үзэж байна.

Өрхийн орлогын өсөлт болон архины үнийн өсөлт хоорондын уялдааг харах, өрхийн орлогын өсөлт нь архины үнийн өсөлтөөс хэр зөрүүтэй байгааг 2000-2020 он хүртэлх 21 жилийн өгөгдлийг ашиглан шинжилж үзлээ.

Доорх зургаас харвал архины үнийн өсөлт нь өрхийн орлогын өсөлтийг дагасан шинжтэй буюу өрхийн орлого өссөн дараагийн жилд архины үнэ дагаж өсдөг гэсэн дүр зураг ажиглагдаж байна.



Зураг 6 Өрхийн орлогын өөрчлөлт ба 0.5л бүхий 38 хувийн хатуулагтай архины үнийн өөрчлөлт

Шинжилгээний үр дүнгээс харвал сүүлийн 21 жилд өрхийн орлого жилд дунджаар 13.4 хувиар нэмэгдэж байсан бол архины үнэ жилд дунджаар 5.4 хувиар нэмэгдсэн байна.

Үүнийг задлан харвал 2001, 2005, 2009, 2013, 2015, 2016 гэсэн 6 жилээс бусад 15 жилд нь өрхийн орлогын өсөлт нь архины үнийн өсөлтийг давж өсөж байсан байна. Хамгийн өндөр зөрүү 2002 онд өрхийн орлогын өсөлт архины үнийн өсөлтөөс 35.2 нэгж хувиар давж гарч байсан байна. Эндээс харвал архины үнэ өрхийн орлоготой харьцуулан авч үзвэл жил болгон илүү хямд үнэтэй болж байна гэсэн үг юм.

Архины үнэ /25-аас 40 хувийн хатуулагтай/ болон 1л архинд ногдох татварын хамаарлын шинжилгээ

Дараагийн алхамд татвар хэдий хэмжээтэй нэмэгдэхэд үнэ хэдий хэмжээтэй өрчлөгдөж байна вэ гэдгийг тодорхойлох асуулт урган гарна. Энэ тохиолдолд 1л архинд ногдох татварыг 1 хувиар нэмэгдүүлэхэд үнэ хэдэн хувиар нэмэгдэж ирснийг түүхэн өгөгдөл ашиглан татвараас хамаарсан үнийн мэдрэмжийг тооцоох замаар тодорхойллоо.

Өмнө таамагласны дагуу архинд ногдуулж буй татвар хатуулгаас хамаараад ялгаатай боловч үнийн өсөлтийн хувь ижил байна гэсэн таамаглалын дагуу ногдуулж буй татварын өсөлтийг Ерөөл архины үнэтэй хамааралтай байдлаар загварчлан тодорхойллоо.

Үнэлгээний үр дүнг загварт харуулсан байдлаар тодорхойлов. /Хавсралт хүснэгт 3/

$$\ln price_t = 5.95 + 0.32 \ln tax_t + 0.05 \ln tax_{t-1}$$

[28.6] [89.6] [2.88]

Үнэлгээний үр дүнгээс харвал татварын 1 хувийн өсөлт нь тухайн хугацаанд архины үнийг дунджаар 0.32 хувиар нэмэгдүүлдэг бол дараагийн хугацаанд энэ нөлөө үргэлжилсээр 0.05 хувиар нэмэгдэж байна. Нийт дүнгээр нь авч үзвэл татвар 1 хувь нэмэгдэхэд архины үнэ нийт дүнгээрээ 0.37 хувиар нэмэгдэж байна.

Архины татварын орлогод нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ /25-аас 40 хувийн хатуулагтай/

Дээр хийгдсэн хоёр тооцоотой холбоотойгоор архины татварын орлогод /25-аас 40 хувийн хатуулагтай/ ямар ямар хүчин зүйлс нөлөөлж болохыг судалж үзэхдээ өмнөх хэсэгт дурдсан дараах хэлбэрийн логарифм загварыг авч үзье.

$$\ln tax_inc_t = \beta_1 + \sum \beta_i \ln x_{it} + e_t$$

Нөлөөлөх хүчин зүйлээр борлуулалтын орлого, амьжиргааны баталгаажих доод түвшин (УБ хот), өрхийн сарын дундаж орлого /улсын хэмжээнд/, 1 л архинд ногдох татвар гэсэн хүчин зүйлүүдээр авч үзлээ.

Өрхийн сарын дундаж орлого, амьжиргааны баталгаажих доод түвшин, 1л Ерөөл архины үнийн мэдээллийг ҮСХ-оос гаргасан өгөгдөлд тулгуурлан, 1 л архинд ногдох татварыг www.legalinfo.mn сайт дахь Онцгой албан татварын тухай хууль, татварын орлогын өгөгдлийг Сангийн яамнаас тус тус авч шинжилгээнд ашиглав. Хугацааны хувьд 2014 оны 1 сараас 2021 оны 6 сар хүртэлх нийт 90 сарын сар бүрийн мэдээлэлд тулгуурлан үнэлгээг хийсэн.

Загварын хувьд зөв тодорхойлогдсон, автокорреляцгүй гарсан байна. Үнэлгээнд Ерөөл архины үнийг оруулсан болон оруулаагүй гэсэн 2 загвараар үнэлж үзсэн. Оруулсан загварын хувьд архины үнэ статистик ач холбогдолгүй гарсан тул үр дүнг тайлбарлахдаа Ерөөл архины үнийг оруулаагүй загвар дээр тайлбарыг хийе. /Хавсралт хүснэгт 4/

Хүснэгт 10 Архины татварын орлогод нөлөөлөгч хүчин зүйл

Хувьсагчид	Загвар 1	Загвар 2
Тогтмол тоон утга	64.56***	64.03**
Архины борлуулалтын орлого	1.16***	1.15***
1 л архины татвар	5.25***	5.23***
Амьжиргааны баталгаажих доод түвшин	-14.57***	-14.63***
Өрхийн сарын орлого	5.55***	5.52**
Ерөөл архины үнэ 500 мл	-	0.21
R ²	0.28	0.28
Тэмдэглэл ***-1%-ийн түвшинд, **-5%-ийн түвшинд, *-10%-ийн түвшинд статистик ач холбогдолтойг илэрхийлнэ.		

Архины борлуулалтын орлого 1 хувиар нэмэгдэхэд архины татварын орлого 1.16 хувиар, өөрөөр хэлбэл архины борлуулалтын орлогоос хамаарсан архины татварын мэдрэмж сайн байгааг илтгэж байна. 1л архины татвар болон өрхийн сарын дундаж орлого 1 хувиар нэмэгдэхэд архины татварын орлого харгалзан 5.25 болон 5.55 хувиар тус тус нэмэгдэж байна. Амьжиргааны баталгаажих доод түвшин нэмэгдэх нь архины татварын орлогыг бууруулдаг гэсэн үр дүн гарч байна. Энэ нь

нэг талаас ажилтай орлоготой байх тусам архины хэрэглээ багасдаг, үүнээс улбаатайгаар архины татвараас орох орлогыг бууруулахад нөлөөлдөг байж болох юм. Учир нь өрхийн орлогыг 5 бүлгээр /бага, бага дунд, дунд, дээгүүр, чинээлэг/ авч үзсэн судалгаанд бага болон бага дунд орлоготой өрхийн нийт орлогод эзлэх архи, согтуулах ундаа тамхины эзлэх хувийн жин бусад бүлгүүдтэй харьцуулахад илүү өндөр хувь эзэлдэг болохыг харуулсан байдаг.¹⁶ Ерөөл архины үнэ энд ач холбогдолгүй гарсан байгаа нь архины татварын орлогыг тайлбарлаж чадахгүй байна.

Архины үнийн мэдрэмжийг QUAIDS загварыг ашиглан тооцсон үр дүн

Загварын үнэлгээний үр дүнгээс улаанаар тэмдэглэсэн гол диогналийн элементүүд нь тухайн барааны үнээс хамаарсан эрэлтийн мэдрэмжийг харуулах бөгөөд диогналийн бус элементүүд нь солбих үнийн мэдрэмжийг харуулж байна.

Шар айргийн үнэ 1 хувиар нэмэгдэхэд түүний хэрэглээ буюу эрэлт 0.095 хувиар буурдаг, дарсны үнэ 1 хувиар нэмэгдэхэд дарсны хэрэглээ 0.055 хувиар, архи вискиний үнэ 1 хувиар нэмэгдэхэд хэрэглээ 0.091 хувиар, янжуур тамхины үнэ 1 хувиар нэмэгдэхэд хэрэглээ 0.041 хувиар, дүнсэн тамхины үнэ 1 хувиар нэмэгдэхэд дүнсэн тамхины хэрэглээ 0.05 хувиар тус тус нэмэгддэг байна.

¹⁶ Enkh-Amgalan.B, Batmunkh.B “The effect of food prices on consumer price index of Mongolia and International experience” TA-6428 REG Supporting Strategic Knowledge Products and Research Networking (3rd Supplementary) (41571-042) 2012.

Хүснэгт 11 Архи согтууруулах ундаа тамхины үнийн болон солбицох үнийн мэдрэмж

Үзүүлэлтүүд	Шар айраг	Дарс	Архи, виски	Янжуур тамхи	Дүнсэн тамхи
	1	2	3	4	5
Шар айрагны үнэ	-0.095 [0.183]	-0.089 [0.032]	-0.040 [0.122]	0.229 [0.073]*	-0.006 [0.037]
Дарсны үнэ	0.000 [0.023]	0.055*** [0.004]	-0.0581* [0.016]	-0.017 [0.009]	0.020 [0.005]
Архи, вискиний үнэ	0.045 [0.102]	0.054* [0.018]	0.091 [0.068]	-0.236 [0.041]	0.041 [0.020]
Янжуур тамхины үнэ	0.100 [0.165]	0.025 [0.029]	-0.119 [0.109]	0.041 [0.066]	-0.043 [0.033]
Дүнсэн тамхины үнэ	-0.036 [0.192]	0.078 [0.034]	-0.011 [0.128]	-0.078 [0.076]	0.050 [0.038]
Хүнсний зарлага	-6.264 [4.972]	2.608* [0.876]	0.061 [3.302]	-1.550 [1.974]	4.954 [0.989]
Квадрат хүнсний зарлага	0.254 [0.206]	-0.114* [0.036]	0.004 [0.137]	0.073 [0.082]	-0.209 [0.041]
Өрхийн гишүүдийн тоо	0.438 [0.842]	0.504* [0.148]	-0.068 [0.559]	-0.836 [0.334]	-0.027 [0.168]
Тогтмол коэффициент	37.316 [30.66]	-17.74* [5.404]	-0.637 [20.362]	13.229 [12.175]	-30.035 [6.102]

Note:***p<0.01, **p<0.05, *p<0.1. Standard errors in parentheses

Солбисон үнийн мэдрэмжийн хувьд архи вискиний үнийн өсөлт шар айргийн, дарсны, дүнсэн тамхины эрэлтийг нэмэгдүүлдэг болдог янжуур тамхины эрэлтийг бууруулдаг байна.

Олон орны судалгаагаар үнийн өсөлт нь архины хэрэглээ буюу эрэлтийг бууруулдаг гэсэн үр дүн гардаг бол Монгол улсын хувьд архины үнийг нэмэгдүүлэх нь эрэлтийг бууруулах нөхцөл болж чадахгүй байна.

Бүлгийн дүгнэлт


1. Өнгөрсөн хугацаан дахь тоон мэдээлэлд үндэслэн тооцоход архи, согтууруулах ундаа үнийн мэдрэмжгүй байна. Энэ нь өрхийн орлогын өсөлт нь архины үнийн өсөлтөөс байнга түрүүлж байгаатай холбон тайлбарлаж болно. Өөрөөр хэлбэл орлогын өсөлт нь жил бүрийн архины үнийн өсөлтөөс давж байгаа тул архи жил бүр өмнөх жилүүдтэй харьцуулахад хямдхан болж байна. Тиймээс өрхүүдийн хувьд архины хэрэглээг бууруулахгүй өдөөх шалтгаан болж байна.
2. Татварын өсөлт нь архины үнийг өсгөдөг, ингэхдээ өмнөх хугацаанд нэмсэн татвар нь тухайн хугацаандаа архины үнийг өсгөхөөс гадна, дараагийн хугацаанд ч архины үнийн шалтгаан болсоор байгааг харуулж байна.
3. Архинаас авах татварын орлогод, архины борлуулалтын орлогын өсөлт, 1 л архины татварын өсөлт, өрхийн сарын орлогын өсөлт нь эерэг нөлөө үзүүлдэг бол амьжиргааны баталгаажуулах доод түвшин нэмэгдэх нь сөрөг нөлөө үзүүлдэг. Өөрөөр хэлбэл амьжиргааны баталгаажих доод түвшин нэмэгдэх нь архинаас орох татварын орлогын дүнг бууруулахад хүргэдэг байна. Загвараас архины үнэ статистик ач холбогдолгүй гарсан байна. Тиймээс архины татварыг нэмэгдүүлэх замаар үнэнд нөлөөлж түүгээрээ борлуулалтын орлогыг өсгөж байна гэсэн дүгнэлт хийж байна.
4. Архины үнийн татварыг огцом нэмэгдүүлэх, энэ нэмэгдэлтийг жил бүр явуулах ингэснээр богино хугацаандаа архины хэрэглээ огцом буурахгүй боловч жил бүрийн үнийн огцом өсөлт нь шокийн шинж чанартай дунд хугацаандаа өрхийн төсөвт дарамт учруулах хэмжээнд хүрэхэд архины хэрэглээ буурахад хүргэж болно. Манай улсад одоогоор ийм шокийн шинжтэй арга хэмжээ авсан түүх байхгүй ч бусад улс оронд архины татварыг огцом нэмэх замаар үнийг өндөр

болгох, үүний үр дүнд хэрэглээг бууруулсан тохиолдлууд бусад улс орны хувьд их байгаа тул архины үнийн өсөлтийг хамгийн багадаа өрхийн орлогын өсөлтөөс илүү байхаар тогтоох нь зүйтэй байна.

5. Нөгөө талаас архины үнэ огцом нэмэгдэх нь бага орлоготой өрхийн эдийн засгийн чадавхад хүчтэй нөлөө үзүүлэх учраас чанар муутай, гар аргаар үйлдвэрлэсэн архины эрэлтийг өсгөх магадлалтай. Иймд шагийн гэж нэрлэгдэх архийг нэмэгдүүлэхгүй байх тал дээр хууль хяналтын байгууллагаас анхаарах.
6. Өмнөх судалгааны үр дүнгүүдээс харвал өрхийн орлого нэмэгдэхийн хэрээр архины хэрэглээ багасаж байгаа нь харагдсан тул цаашид өрхийн амьжиргааны түвшнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх тал дээр ажиллах.

АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНД ТАТВАР ТООЦОХ АРГЫГ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН

Хүн амын дунд өргөн хэрэглэдэг, олдоц сайтай дотоодын согтууруулах ундааны борлуулалтын үнийг татваргүй үнэ, НӨАТ болон ноогдож буй онцгой татварын хэмжээг харуулав. (Зураг 7) Борлуулалтын нийт үнэд эзлэх ОАТ-ын хувь нь харилцан адилгүй байна. Тооцоолж үзэхэд шар айрагт дундажаар 6.6 хувь болон цагаан архинд 32 хувь эзэлж байна. Бидний тойм судалгааны үр дүнгээс харахад бусад улс орнуудад борлуулалтын үнэд эзлэх ОАТ-ын хувь нь шар айрагт 20-ээс дээш хувьтай, цагаан архинд 50-аас дээш хувьтай байсан. Өөрөөр хэлбэл борлуулалтын үнэд эзлэх ОАТ-ын хэмжээ нь дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад манай мөрдөж буй онцгой татварын хэмжээг 2-3 дахин нэмэгдүүлэх шаардлагатай байна.



Зураг 7 Согтууруулах ундааны үнэ, татварын хувь хэмжээ

Өргөн хэрэглэгддэг согтууруулах ундааны үнийн мэдээллийг ашиглан ОАТ-ын хувийг шар айрагт 20, 30, 40 хүртэл хувиар, цагаан архины 40, 50, 60 хүртэл хувиар тус тус нэмэгдүүлж хувилбаруудыг тооцов. (Хүснэгт 12) Жишээ нь 450мл шар айраг зах зээл дээр 2400₮ борлуулагдаж байна. Бүтээгдэхүүнд ноогдож буй ОАТ-ын суурь хэмжээ нь 158₮ буюу үнэд эзлэх ОАТ 6.6 хувь байна. Үнэд эзлэх

ОАТ-ын хэмжээг 20, 30, 40 хүртэл хувиар нэмэгдүүлэхийн тулд суурь татварын хэмжээг 3.85, 7,09 болон 11.8 дахин өсгөх шаардлагатай байна. Ингэснээр бүтээгдэхүүний борлуулалтын үнэ 2400₮ -өөс 3033₮, 3717₮ болон 4643₮ болж нэмэгдэнэ.

Түүнчлэн 750мл хэмжээтэй дотоодын өргөн хэрэглээний цагаан архи зах зээл дээр 18000₮ борлуулагдаж байгаа бөгөөд бүтээгдэхүүнд ноогдох суурь ОАТ-ын хэмжээ нь 5220₮ буюу үнэд эзлэх ОАТ 29 хувь байна. Цаашид үнэд эзлэх ОАТ-ын хэмжээг 40, 50, 50 хүртэл хувиар нэмэгдүүлэхийн тулд суурь татварын хэмжээг 1.8, 2.9 болон 5 дахин өсгөх шаардлагатай байна. Ингэснээр цагаан архины борлуулалтын үнэ 18000₮ -өөс 23710₮, 30345₮ болон 40275₮ болж тус тус нэмэгдэнэ.

Хүснэгт 12. Шар айрагт тооцсон татварын тооцоо

Шар айраг	Борлуулалтын үнэ ₮	ОАТ ₮	Тохируулагч	Онцгой татварын эзлэх хувь
Жишээ 1. Шар айраг (450 мл, Alc 5.5%)				
Суурь үнэ	2,400	158		6.6%
Үнэд эзлэх ОАТ 20%	3,033	606	3.85	20%
Үнэд эзлэх ОАТ 30%	3,717	1,117	7.09	30%
Үнэд эзлэх ОАТ 40%	4,643	1,859	11.8	40%
Жишээ 2. Цагаан архи (750мл, Alc 38%)				
Суурь үнэ	18,000	5,220		29%
Үнэд эзлэх ОАТ 40%	23,710	9,500	1.8	40%
Үнэд эзлэх ОАТ 50%	30,345	15,138	2.9	50%
Үнэд эзлэх ОАТ 60%	40,275	24,012	5	60%

Бүтээгдэхүүний үнэ тодорхой хувиар нэмэгдсэнээр согтууруулах ундаанд ноогдуулах татварын хэмжээ татвар тооцох арга тус бүрд хэрхэн өөрчлөгдөхийг судлав. (Хүснэгт 13) Жишээ нь 450 мл савлагаатай 5.5 хувийн хатуулагтай шар айрагт 2.5 стандарт уулт (1 стандарт уулт=10 мл этилийн спирт), харин 750 мл, 38 хувь хатуулагтай цагаан архинд 28.5 стандарт уулт тус тус ноогдож байна. Тухайн бүтээгдэхүүнд ноогдох уултын тоог тодорхойлсноор нэгж (стандарт) уултад ноогдуулах доод үнийг тооцох боломжтой. Энэхүү арга нь бүтээгдэхүүний савлагаа болон хатуулгын хэмжээнд үндэслэн тооцдог тул үр дүнтэй татварын зохицуулалт хийх, хэрэглээг бодитой бууруулах ач холбогдолтой аргад ордог.

Борлуулалтын үнэд үнэд эзлэх ОАТ хэмжээг шар айрагт 20, 30, 40 хүртэл хувиар нэмэгдүүлснээр нэгж стандарт уултад ноогдох доод үнийн зохицуулалтын үед 960 төгрөгийн суурь үнийг 1214₮, 14874₮, 1857₮ хүртэл хэмжээнд хүргэх шаардлагатай байна. Харин нэгж хатуулагт ноогдох татварын аргын үед одоогийн 29₮ суурь татварыг 110₮, 203₮, 338₮ хүртэл хэмжээнд хүргэх шаардлагатай байна. Цагаан архины хувьд нэгж уултад ноогдох доод үнийг 632 ₮ суурь хэмжээнээс 832₮-1413₮ хүртэл хэмжээнд хүргэх шаардлагатай.

Аливаа бүтээгдэхүүний үнэ өсөхөд хэрэглээ дагаад буурч байдаг. Архи, согтууруулах ундааны үнэ 10% нэмэгдүүлэхэд архины хэрэглээ дундажаар 7.8 хувиар, шар айраг 5 хувиар тус тус буурдаг. Согтууруулах ундаа нь бусад төрлийн бүтээгдэхүүнтэй харьцуулахад донтуулах шинжтэй, үнийн хувьд мэдрэмж багатай бүтээгдэхүүнд тооцдог.

Борлуулалтын үнэд эзлэх ОАТ хэмжээг шар айрагт 20-40 хувь хүртэл, цагаан архинд 40-60 хүртэл хувиар нэмэгдүүлснээр шар айрагны хэрэглээ 6-16 хүртэл хувиар, цагаан архи 11-27 хувиар тус тус буурах боломжтой байна.

Хүснэгт 13. Татвар тооцох аргуудыг харьцуулсан байдал

Шар айраг	Стандарт уултын тоо	Нэгж стандарт уултанд ноогдох үнэ ₮	Нэгж хатуулагт ноогдох татвар ₮	ОАТ ₮	Хэрэглээнд гарах өөрчлөлт (хувиар)
Жишээ. Шар айраг (450 мл, Alc 5.5%)					
Суурь үнэд	2.5	960	29	158	
Үнэд эзлэх ОАТ 20%	2.5	1,214	110	606	-6%
Үнэд эзлэх ОАТ 30%	2.5	1,487	203	1,117	-11%
Үнэд эзлэх ОАТ 40%	2.5	1,857	338	1,859	-16%
Жишээ. Цагаан архи (750мл, Alc 38%)					
Суурь үнэ	28.5	632	137	5,220	
Үнэд эзлэх ОАТ 40%	28.5	832	250	9,500	-11%
Үнэд эзлэх ОАТ 50%	28.5	1,065	398	15,138	-18%
Үнэд эзлэх ОАТ 60%	28.5	1,413	632	24,012	-27%

Бүлгийн дүгнэлт хийх:

1. Архи, согтууруулах ундаанд ноогдуулсан онцгой татварын зохицуулалт нь үр дүнгүй, хэрэглээг бууруулах хөшүүрэг болж чадахгүй байна. Согтууруулах ундаанд ноогдуулсан онцгой татварын хэмжээ нь бүтээгдэхүүний хатуулаг (градус) болон эзлэхүүний (савлагаа) хэмжээтэй уялдаагүй байна.

2. Борлуулалтын үнэд эзлэх ОАТ хувь нь шар айрагт 7%, цагаан архинд 30 орчин хувьтай байгаа нь олон улсын зөвлөмж, бусад улс орны туршлагатай харьцуулахад бага байна. Иймд борлуулалтын үнэд эзлэх ОАТ хэмжээг хатуулаг багатай шар айрагт 20%-40% хүргэх, хатуулаг ихтэй цагаан архинд 40%-60% хүргэхийн тулд одоогийн суурь татварын хэмжээг согтууруулах ундааны төрлөөс

хамаарч шар айрагт хамгийн багадаа 4-12 дахин, цагаан архинд багадаа 2-5 дахин нэмэгдүүлэх шаардлагатай байна.

3. Согтууруулах ундааны төрлүүд дотор дотоодын цагаан архины үнэ бусад төрлийн согтууруулах бүтээгдэхүүний үнэтэй харьцуулахад хамгийн хямд байна. Иймд стандарт уултаар тооцсон доод үнэ тогтоох зохицуулалтыг хэрэгжүүлснээр хэрэглээг богино хугацаанд бууруулах боломж бүрдэнэ.

4. Оновчтой татварын бодлого нь архины хэрэглээг дорвитой бууруулж, архины шалтгаант өвчлөл болон эдийн засгийн үргүй зардлыг хэмнэх боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ. Хүн амын дундах архины хэрэглээг 18 хувиар бууруулахын тул нэгж уултын доод үнийг одоогийн байгаа 632₮-оос 1065₮ байхаар тогтоох боломжтой. Эсрэгээрээ нэгж хатуулагт суурилсан татварын аргын үед одоогийн суурь 140 ₮ -ийг 400₮ хэмжээнд хүргэж нэмэгдүүлэх гэсэн хувилбаруудаас сонгох боломжтой байна.

5. Архины хэрэглээг үр дүнтэй хянаж чадсан бусад улс орнуудад туршлагаас харахад доод үнэ тогтоох болон хатуулагт суурилсан татварын арга нь архины хэрэглээ өндөртэй, ядуу эмзэг бүлэгт богино хугацаанд хэрэглээг бууруулах үр дүнтэй болох нь судлагдсан байна.


6. Цаашид энэхүү судалгааг эдийн засгийн ялгаатай бүлгүүдэд нарийн судлах шаардлагатай байна.

АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭНЭЭС ҮҮДЭЛТЭЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨЛӨӨЛӨЛ

Хүн амын дундах архины хэрэглээ

Хүн амын тоо, төрөлт, нас баралт, хүйсийн бүтцийн талаарх статистик тоо мэдээллийн ашиглан хүн амын ирээдүйн төлөвийг урьдчилан тооцоолсон үр дүнгээс харахад нийт хүн амын тоо 2051 он гэхэд 3.2 саяас 5.3 сая хүрэх төлөвтэй байна.

Хамгийн сүүлд хийгдсэн хүн амын дундах ХБӨ-ийн эрсдэлт хүчин зүйлийн судалгаагаар сүүлийн 1 сард архи, согтууруулах ундааг эрсдэлтэй хэмжээнд хэрэглэдэг (эрэгтэйчүүд 40г-аас дээш, эмэгтэйчүүд нь 20г-аас дээш) бүлгийн түвшин 2021 оны байдлаар 14.7% буюу 478 мянган хүн архийг эрсдэлтэй түвшинд хэрэглэж байна гэсэн тооцоо гарсан байна. Цаашид архи, согтууруулах ундааны талаар дорвитой бодлого хэрэгжүүлэхгүй, архины хэрэглээ урт хугацаанд үргэлжлэн гэж тооцоход хүн амын өсөлттэй холбоотойгоор архийг эрсдэлтэй түвшинд хэрэглэдэг хүний тоо жилд дунджаар 9.4 мянгаар буюу даруй 4 дахин нэмэгдэх төлөвтэй байна.



Зураг 8 Хүн амын дундах архины эрсдэлтэй түвшинд хэрэглэдэг бүлгийн хэтийн төлөв

Архинаас шалтгаалсан өвчлөлийн хандлага

Архи, согтууруулах ундааны эрсдэлтэй хэрэглээнээс үүдэлтэй эрүүл мэндэд учирч буй дарамт өндөр хэвээр байна. Судалгаанаас харахад архины шалтгаант 200 орчим өвчлөл бүртгэгдсэн байна. Эдгээрээс Монголчуудын дунд зонхилон тохилдож, хүн амын нас баралтын голлох шалтгаан болон архи, согтууруулах ундаанд хамгийн өндөр хамааралтай оношийн дараах 5 бүлгийн тоо мэдээллийн ашиглан урт хугацааны хэтийн төлөвийг тооцов.

Тооцооллоос харахад архины хамраалтай өвчлөл улам нэмэгдэх хандлагатай байна. Жишээ нь элэгний өмөн өвчнөөр 2030 он гэхэд 83 мянган хүн, 2040 он гэхэд 219 мянга, 2050 он гэхэд 387 мянга болж нэмэгдэх хандлагатай байна. Түүнчлэн ХБӨ-ний тархалт нь хавдрын өвчлөлтэй харьцуулахад даруй 3-аас 28 дахин өндөр тархалттай байх хандлагатай байна.

Хүснэгт 14 Архины шалтгаант зарим оношийн бүлгийн хуримтлагдсан тархалт, хүйсээр

Хугацаа (жил)	Уруул өмөн (C00-C14)	амны Улаан өмөн (C15)	хоолойн Элэгний өмөн (C22)	Цочмог панкреатит (K85)	Элэгний цирроз (K74)
Эрэгтэй					
2021-2030	3,827	8,479	44,479	85,211	100,461
2031-2040	8,857	22,631	117,330	149,433	212,848
2041-2051	14,552	40,007	201,431	223,089	334,772
Эмэгтэй					
2021-2030	2,351	7,457	38,340	174,662	109,426
2031-2040	5,344	21,533	102,522	300,959	210,789
2041-2051	9,143	41,045	185,948	452,711	326,658
Бүгд					
2021-2030	6,178	15,937	82,819	259,873	209,887
2031-2040	14,201	44,164	219,852	450,391	423,638
2041-2051	23,695	81,051	387,380	675,800	661,430

Архины хэрэглээг хянах олон хөтөлбөрүүдийн хэрэгжүүлснээр залуучуудыг архинд орохоос сэргийлэх болон насанд хүрэгчдийг архинаас гарах боломжтой болно. Хөтөлбөрүүдийн харьцуулж үзэхэд хамгийн олон хүнийг хамгаалах боломжтой хөтөлбөр нь хүн амд чиглэсэн татварын бодлого бөгөөд үнэ өндөр хувиар нэмэгдэхэд архинаас гарах хүний тоо эрэгтэйчүүдэд 12 мянгаас 36 мянга, эмэгтэйчүүдэд 7 мянгаас 20 мянган хүн байна. Сургуулийн сурагчдад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлснээр 6 мянган залуучуудыг, 4 мянган охидыг архинд орохоос хамгаалж чадаж байгаа бол эмчилгээ шинжилгээг нэмэгдүүлэх хөтөлбөрийн үед 3.4 мянган эрэгтэй, 2.6 мянган эмэгтэйчүүдийн архинаас гаргаж чадаж байна.

Хүснэгт 15 Хөтөлбөр хэрэгжүүлснээр сэргийлэх боломжтой өндөр эрсдэлтэй архи хэрэглэдэг хүний тоо (мянган хүн)

Жил	Борлуулалтын үнэд эзлэх ОАТ			30 аас доош насны бүлэг	40+ насны бүлэг
	40%	50%	60%	10%	10%
Эрэгтэйчүүд					
2021	31.3	62.6	93.9	11.7	14.0
2022	29.9	59.8	90.2	10.8	13.6
2023	30.5	60.9	91.3	11.7	13.3
2025	28.8	57.5	86.4	11.2	12.3
2035	21.9	43.8	65.5	8.6	8.7
2045	14.7	29.4	44.7	7.2	4.3
2051	12.1	24.2	35.8	6.1	3.4
Эмэгтэйчүүд					
2021	16.5	32.9	49.4	6.8	7.5
2022	16.2	32.5	48.7	6.8	7.4
2023	15.2	30.4	45.6	5.9	7.2
2024	14.7	29.4	44.3	5.8	6.9
2025	11.1	22.3	33.6	5.3	3.9
2035	8.4	16.8	25.2	4.9	2.6
2045	6.8	13.5	20.2	3.7	2.2

Эдгээр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр сэргийлэх боломжтой, архидалттай холбоотой өвчлөлийг тооцож үзэхэд хүн амд чиглэсэн татвар нэмэгдүүлэх хөтөлбөр хамгийн өндөр үр дүнтэй байна. Жишээ нь борлуулалтын үнэд эзлэх ОАТ хэмжээг 40% хүртэл хэмжээнд нэмэгдүүлснээр хэрэглээ 11% буурах боломжтой. Үүнтэй холбоотойгоор 43 мянган архины шалтгаанд өвчлөлөөс


сэргийлэх боломжтой бөгөөд ОАТ хэмжээг 60% хүртэл хэмжээнд хүргэснээр хэрэглээ 27% буурч, үүнтэй холбоотойгоор 130 мянган өвчлөлийг хамгаалах боломжтой байна. Аль ч хөтөлбөр хувьд хөтөлбөрийн үр дүнг хамгийн өндөр хүртэх бүлэг нь эрэгтэйчүүд байх ба ХБӨ болох элэгний цирроз болон панкреатит оноштой өвчлөл урт хугацаанд илүү хурдтай буурна.

Хүснэгт 16 Хөтөлбөр хэрэгжүүлснээр сэргийлэх боломжтой өвчлөлийн тоо (2021-2051 он, мянган хүн амаар)

Хөтөлбөрүүд	Уруул амны өмөн	Улаан хоолойн өмөн	Элэгний өмөн	Цочмог панкреатит	Элэгний цирроз	Нийт өвчлөл
	(C00-C14)	(C15)	(C22)	(K85)	(K74)	
Эрэгтэйчүүд						
Үнэд эзлэх ОАТ 40 хувь хүргэх	1.03	1.48	2.65	5.14	16.88	27.2
Үнэд эзлэх ОАТ 50 хувь хүргэх	2.06	2.96	5.30	10.27	33.72	54.3
Үнэд эзлэх ОАТ 60 хувь хүргэх	3.11	4.46	7.98	15.39	50.74	81.7
Залууст чиглэсэн хөтөлбөр	0.19	0.15	0.49	2.25	4.03	7.1
Эмчилгээний хөтөлбөр	0.63	1.13	1.59	1.64	9.34	14.3
Эмэгтэйчүүд						
Үнэд эзлэх ОАТ 40 хувь хүргэх	0.203	0.323	0.532	1.431	13.202	15.7
Үнэд эзлэх ОАТ 50 хувь хүргэх	0.406	0.646	1.065	2.863	26.423	31.4
Үнэд эзлэх ОАТ 60 хувь хүргэх	0.612	0.975	1.615	4.311	39.896	47.4
Залууст чиглэсэн хөтөлбөр	0.049	0.026	0.082	0.737	4.445	5.3

Эмчилгээний хөтөлбөр	0.125	0.271	0.379	0.400	6.336	7.5
Бүгд						
Үнэд эзлэх ОАТ 40 хувь хүргэх	1.24	1.81	3.19	6.57	30.08	42.88
Үнэд эзлэх ОАТ 50 хувь хүргэх	2.47	3.61	6.37	13.13	60.15	85.73
Үнэд эзлэх ОАТ 60 хувь хүргэх	3.72	5.44	9.60	19.70	90.63	129.09
Залууст чиглэсэн хөтөлбөр	0.24	0.18	0.57	2.99	8.47	12.45
Эмчилгээний хөтөлбөр	0.75	1.40	1.97	2.04	15.67	21.83

Хөтөлбөр хэрэгжүүлснээр урт хугацаанд буурах боломжтой өвчлөлийн хандлагыг элэгний өмөн өвлөл дээр жишээгээр харуулав. (Зураг 9) Хүн амд чиглэсэн татварыг нэмэгдүүлэх хөтөлбөр болон өвчлөл өндөртэй 40-оос дээш насны бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүдийн үр дүн богино хугацаанд шууд ажиглагдах бол сургуулийн сурагчдын хөтөлбөр нь урт хугацаанд илүү үр дүнтэй, үр ашигтай өндөртэй байх болно. Энэхүү хандлага нь бусад оношны бүлгүүд дээр ижил чиг хандлагатай байсан.



Зураг 9 Элэгний өмөн өвчлөлийн урт хугацаанд буурах чиг хандлага

Хөтөлбөр хэрэгжүүлснээр хүн амын дундах өвчлөл нас баралт буурна. Дараах хүснэгтээр хөтөлбөрийн үр дүнд аврагдах боломжтой хөдөлмөрийн чадвар алдалтаар тохируулсан амьдралын жилүүдийг харуулав. Нийт хүн амд чиглэсэн хөтөлбөрийн үед ХЧА тохируулсан аврагдах боломжтой жилийн тоо хамгийн өндөр буюу 5 мянгаас 16 мянган жил байх бол бусад хөтөлбөрүүдэд 1 мянгаас 3500 жилийг аварч чадна.

Хүснэгт 17 Аврагдах боломжтой ХЧА-аар тооцсон жилүүд

Хөтөлбөрүүд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Үнэд эзлэх ОАТ 40 хувь хүргэх	3840	1610	5450
Үнэд эзлэх ОАТ 50 хувь хүргэх	7670	3220	10890
Үнэд эзлэх ОАТ 60 хувь хүргэх	11400	4890	16290
Залууст чиглэсэн хөтөлбөр	798	278	1076
Эмчилгээний хөтөлбөр	2400	1100	3500

Хүснэгтээр хөтөлбөр хэрэгжүүлснээр хэмнэгдэх боломжтой эрүүл мэндийн салбарын зардлын хэмжээг урт хугацаанд 3 хувь бууруулж, өнөөгийн үнэ цэнээр тооцож үзэхэд татварын хөтөлбөр хамгийн өндөр хэмжээтэй байна. Үүнд татварын бодлого хэрэгжүүлснээр нийт 52 тэрбумаас 150 тэрбум хүртэл төгрөгийн зардлыг хэмнэх боломжтой.

Хүснэгт 18 Эрүүл мэндийн салбарын зардлын хэмнэлт, өнөөгийн үнэ цэнэ 3% тооцсон (тэрбум төгрөг)

Хөтөлбөр	Уруул амны өмөн	Улаан хоолойн өмөн	Элэгний өмөн	Цочмог панкреатит	Элэгний цирроз	Нийт
	(C00-C14)	(C15)	(C22)	(K85)	(K74)	тэрбум. төг
Үнэд эзлэх ОАТ 40 хувь хүргэх	0.7	0.6	2.1	4.0	45.2	52.5
Үнэд эзлэх ОАТ 50 хувь хүргэх	1.4	1.2	4.2	7.9	90.4	105.1
Үнэд эзлэх ОАТ 60 хувь хүргэх	2.0	1.9	6.3	11.9	136.2	158.2
Залууст чиглэсэн хөтөлбөр	0.1	0.1	0.3	1.7	11.7	13.9
Эмчилгээний хөтөлбөр	0.4	0.5	1.4	1.3	24.8	28.5

Бүлгийн дүгнэлт

1. Урт хугацаанд нийт хүн амын тоо 5.3 сая хүрэх бөгөөд энэхүү өсөлттэй холбоотойгоор архийг эрсдэлт хэмжээтэй хэрэглэдэг хүн амын тоо жилд дунджаар 9 мянгаар нэмэгдэх хандлагатай байна.
2. Үүнтэй холбоотойгоор архины шалтгаант өвчлөл нэмэгдэнэ. Жишээ нь элэгний өмөн өвчнөөр 2030 он гэхэд жилд дундажаар 8 мянган хүн, 2040 он гэхэд 22 мянга, 2050 он гэхэд 38 мянга болж нэмэгдэх хандлагатай байна. Түүнчлэн ХБӨ-ний тархалт нь хавдрын өвчлөлтэй харьцуулахад даруй 3-аас 28 дахин өндөр тархалттай байх хандлагатай байна.
3. Архинаас шалтгаалсан өвчлөл, эндэгдлийн тодорхой хувийг урьдчилан сэргийлэх боломжтой. Бидний тооцоолсноор хүн амд чиглэсэн татварын оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлснээр 5.5 мянгаас 16 мянган жилийг, 18-30 хүртэл насны залуучуудад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлснээр 1100 жилийг, 40-оос дээш насны бүлэгт эмчилгээний хөтөлбөрийг эрчимжүүлснээр 3500

жилийг тус тус алдахаас сэргийлэх боломжтой байна. Эдгээр хөтөлбөрүүдийг хослуулан хэрэгжүүлснээр нийт 10 мянгаас 15 мянга жилийг алдахаас сэргийлэх боломжтой байна.

4. Ялангуяа эрэгтэйчүүдийн дунд архины шалтгаант эрсдэл эмэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр байгаа бөгөөд хөтөлбөр хэрэгжүүлснээр үр дүнг хамгийн өндөр хүртэх бүлэг нь эрэгтэйчүүд байна.
5. ХБӨ-ний хувьд эдгэрэлт удаан, өвчлөлийн явц удаан байдаг тул хүн амын хөдөлмөрийн чадвар алдуулах, амьдралын чанарыг бууруулах сөрөг нөлөөтэй, урт хугацааны эмчилгээ шинжилгээ, идэвхтэй хяналт шаардгагдаж байдаг тул эмчилгээний өндөр зардал, санхүүгийн дарамтыг өрх гэр, эрүүл мэндийн салбарт учруулж байдаг. Бидний тооцсоноор олон УС хөтөлбөрийг хослуулан хэрэгжүүлснээр эрүүл мэндийн салбарын санхүүжилтэд 14 тэрбум-158 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргах боломжтойг тооцов.
6. Бид нэг удаагийн хөтөлбөрийн үр дүнг тооцсон. Бодит байдал дээр архины хэрэглээг дорвитой бууруулахыг тул татвар болон бусад урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг жил бүр буюу урт хугацаанд тогтмол хэрэгжүүлэх шаардлагатай. Ингэснээр хэрэглээг бууруулах, өвчлөл нас баралтаас сэргийлэх, эрүүл мэндийн үргүй зардлыг хэмнэх боломж бүрдэнэ.